



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ
ТӨВ

Монгол Улс

*Хэвлэл мэдээллийн эрх зүй.
Онлайн, оффлайн орчин дахь
хувь хүний нууц ба цахим эрх
Сургалтын гарын авлага*

2017 оны хоёрдугаар сар Агуулга

ТАНИЛЦУУЛГА	4
ХӨТӨЛБӨР	6
МОДУЛЬ 1: ХУВЬ ХҮНИЙ НУУЦЫН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХЭМ ХЭМЖЭЭ	7
1. Танилцуулга	7
2. Хувь хүний нууцын эрх зүйн тодорхойлолт	9
3. Хувийн нууцын хязгаарлалт	14
Ном зүй	17
МОДУЛЬ 2: ХУВЬ ХҮНИЙ НУУЦ БА ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ ЧӨЛӨӨ	18
1. Эерэг хүчин зүйл	19
2. Зөрчилдөөн: Олон нийтийн эрх ашгийн шалгуур үзүүлэлт	20
Ишлэл/Ном зүй	26
ХУВИЙН НУУЦТАЙ ХОЛБООТОЙ ДАСГАЛ АЖИЛ	26
МОДУЛЬ 3: ХУВЬ ХҮНИЙ НУУЦ, ӨГӨГДӨЛ ХАМГААЛАЛТ БА МЭДЭЭЛЭЛТЭЙ БАЙХ ЭРХ	27
1. Өгөгдөл хамгаалалт ба Хувь хүний нууц	27
2. Өгөгдөл хамгаалах стандартууд	28
3. Хувь хүний нууц, Өгөгдөл хамгаалалт ба Мэдээлэл олж авах эрхийн тухай хууль	34
Ном зүй	36
Модуль 4: Онлайн хувийн нууц ба мөрдөн тагнах	37
1. Ерөнхий зарчмууд	37
2. Олон улсын хэм хэмжээ	40
Ном зүй	46
Хувийн нууцын талаар дүрүүдэд тоглох дасгал	47
Модуль 5: Цахим орон зайн асуудлууд	48
1. Интернэтийн бүтцийн зохицуулалт	48
2. Оюуны өмч ба зохиогчийн эрх	53
3. Агуулгын асуудлууд	56
Ном зүй	60
ЦАХИМ ОРОН ЗАЙТАЙ ХОЛБООТОЙ ДАСГАЛ АЖИЛ	60

ТАЛАРХАЛ

Тус гарын авлагыг Эрх зүй ба ардчилал төвийн гүйцэтгэх захирал Тоби Мендел боловсруулж, Дойче Велле Академийн дэмжлэгтэйгээр орчуулан түгээв.

ТАНИЛЦУУЛГА

Хэвлэлийн эрх чөлөөг багтаасан үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь суурь эрх хэмээн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх мөн. Бие даасан эрхийнхээ хувьд чухал хэдий ч энэхүү эрх нь бусад олон өөр эрхийг хүндэтгэх, хамгаалах үндэс болдог. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэх байдалд халдахад бусад бүх эрх эрсдэлд ордог. Бүх эрх, цаашлаад ардчиллыг ханган, хамгаалахад гүйцэтгэх үүргийнх нь хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь анхдагч суурь эрхүүдийн нэг хэмээн нийтээр хүлээн зөвшөөрөгддөг билээ.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөтэй хамт энэхүү эрхийг дэмжигч, зарим тохиолдолд энэхүү эрхтэй зөрчилдөгч хувь хүний нууцтай байх эрх шууд холбоотой сөхөгддөг. Цахим орон зайд хувь хүний нууцтай байхтай холбоотой уламжлалт ойлголт, эрх зүйн тогтолцоонуудаас давсан, урьд өмнө үүсч байгаагүй сорилтууд өнөө цагт үүссээр байна.

Эдгээр эрхийг баталгаажуулах олон улсын эрх зүй, үндсэн хуулийн баталгаа, зарчмуудыг үзвэл хэдхэн өгүүлбэрт багтсан байдаг хэдий ч эдгээр эрх нь нэн өргөн, ярвигтай. Нэг талаас энэ нь олон улсын эрх зүйгээр үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө болон хувь хүний нууцын тухай зохицуулалтыг хувь хүмүүсийн ашиг сонирхлыг үл хамааран бүх нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс улс орнууд өөрсдөө зохицуулах эрхийг эдэлдэгтэй холбоотой. Гэхдээ эдгээр эрх нь эерэг элементыг агуулдаг буюу улс орнууд эдгээр эрхийг хязгаарлахаас татгалзаад зогсохгүй, нийт нийгэмдээ эдгээр эрхийг хүндлэх арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг гэсэн үг. Хувийн нууцын асуудлыг илүү ярвигтай болгодог өөр нэг зүйл нь бид өөрсдөө зөвшөөрснөөр хувийн нууцаа хадгалах эрхээ эдлэх эрхээс татгалзаж болдог бас нэг элемент байдаг.

“Хэвлэл мэдээллийн эрх зүй: онлайн болон оффлайн орчин дахь хувийн нууц ба цахим эрх” сургалтын гарын авлага нь олон хэлбэр байдлаар илрэх хувь хүний нууц ба онлайн буюу цахим орон зайд үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө гэсэн хоёр үндсэн асуудал дээр төвлөрсөн сургалтын хүрээ, агуулга юм. Энэхүү гарын авлагын бүтэц нь сургалтад ашиглах зорилготой ч, цаашид хэрэглэхүйц лавлах ном болгон ашиглаж болно.

Гарын авлага нь монголын шинжээчдийн гурван хэсгээс гадна олон улсын эрх зүй дээр төвлөрсөн таван модуль хэсгээс бүрдэж байна. “Хувь хүний нууцын тухай олон улсын хэм хэмжээ” гэсэн эхний модуль нь энэхүү эрхийн талаар олон улсын эрх зүйн үндсэн хэм хэмжээ, олон улсын эрх зүйн баталгаа, эрх зүйн тодорхойлолт, томъёолол болон энэхүү эрхийн хязгаарлах хүрээний талаар өргөн мэдлэг өгнө.

Хоёр дахь модуль нь хувь хүний нууц болон үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний ярвигтай харилцан уялдааг задлаж үзнэ. Эдгээр эрхийн харилцан нөхцөлдөх, харилцан дэмжих байдлууд, мөн эдгээр эрх зөрчилдсөн тохиолдолд олон улсын эрх зүйн хэм хэмжээ хэрхэн үүнийг зохицуулдаг талаар авч үзнэ.

Гурав дахь модуль нь хувь хүний нууц, өгөгдөл хамгаалах болон мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөг шинжилнэ. Хувь хүний нууц ба мэдээлэл буюу өгөгдөл хамгаалах нь хоорондоо нягт холбоотой ч мөн чанарын хувьд өөр буюу зарим талаараа бие биеэсээ илүү өргөн, эсвэл явцуу хүрээний зохицуулалтыг агуулдаг ойлголтууд. Аль аль ойлголтыг мэдээлэл хүртэх эрхийг хязгаарлахад ашигласаар ирсэн. Ингэх нь гарцаагүй хуулийн дагуу заримдаа хийгдэх ёстой дээр бүгд санал нэгддэг ч зарим улс орны хууль, шүүх эдгээр эрхийг зохистой байдлаар тэнцвэржүүлж өгөөгүй байдаг.

Дөрөв дэх модулиар өнөө цагт нэн тулгамдаж буй хувь хүний нууц ба мөрдөн тагнах асуудлыг авч үзнэ. Снөүдэний 2013 оны илчлэлээс хойш энэ асуудал хувь хүний нууцын талаарх олон улсын түвшний мэтгэлцээний гол асуудал болсоор байгаа. Энэ модулиар хэрхэн шинэ технологи нь нийтийг мөрдөн тагнах үйл ажиллагааг боломжтой болгож буй талаар, мөн энэхүү үйл ажиллагааг хязгаарлах үндэс болсон хувь хүний нууцтай байх эрхийн талаарх хэд хэдэн олон улсын хэм хэмжээг задлаж үзнэ.

Тав, зургаа дахь модулиар цахим орон зай, ялангуяа интернэт дэх үг хэлэх эрхийн зохицуулалтын асуудлыг авч үзнэ. Интернэтийн бүх дэлхийг хамарсан, үнэндээ улс орнуудын хил хязгаарыг давсан мөн чанар нь улс орнуудын хувьд шийдвэрлэхэд бэрх асуудлуудыг үүсгэдэг. Бусдад бодит гэм хор учруулах үг, илэрхийллийг таслан зосгоох, урьдчилан сэргийлэх ёстой утгаар тодорхой зохицуулалт шаардлагатай ч олон орны хууль интернэтийн өвөрмөц мөн чанарыг үл ойлгосон, зохисгүй хэт зохицуулалт хийж байна.

Үндсэн хичээлүүдийн дундуур оролцогсад хэд хэдэн дасгал ажил дээр ажиллах ба дасгалуудын танилцуулгыг тухай бүрт нь тараана. Энэхүү сургалт нь бүлгийн ажил, хэлэлцүүлэг, мэтгэлцээн гэх мэт оролцоонд тулгуурласан аргачлалыг түлхүү ашиглах ба хэлэлцүүлгийн сэдвүүдийг гарын авлагад багтаасан.

**Хэвлэл мэдээллийн эрх зүй: онлайн, офлайн орчин дахь
хувийн нууц ба цахим эрх чөлөө
Сургалтын хөтөлбөр**

**Дойче Велле Академи/ Глоб Интернэшнл Төв
Сургагч багш: Тоби Мендел, Хууль ба ардчилал Төв
2017 оны 2 дугаар сарын 07-08-ны өдөр (2 өдөр)**

ӨДӨР 1: Мягмар гараг, 2017 оны 2 дугаар сарын 07

- 09:00-09:15 Нээлт
- 09:15-09:45 Танилцуулга, хөтөлбөр, хүлээж буй үр дүн
- 09:45-10:45 Хувь хүний нууцын талаарх олон улсын ерөнхий хэм хэмжээ
- 10:45-11:00 Цайны завсарлага
- 11:00-12:30 Хувь хүний нууц: Монголын хууль тогтоомж
- 12:30-13:30 Үдийн хоол
- 13:30-14:30 Хувь хүний нууц ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө
- 14:30-15:15 Хувь хүний нууцтай холбоотой дасгал ажил
- 15:15-15:30 Цайны завсарлага
- 15:30-17:00 Хувийн нууц ба өөрийн зохицуулалт

ӨДӨР 2: Лхагва гараг, 2017 оны 2 дугаар сарын 08

- 09:00-10:00 Хувь хүний нууц, өгөгдөл хамгаалалт ба мэдээлэл олж авах эрх
- 10:00-11:00 Онлайн орчин дахь хувийн нууц ба мөрдөн тагнах ажиллагаа
- 11:00-11:15 Цайны завсарлага
- 11:15-12:30 Хувийн нууцын талаар дүрүүдэд тоглох дасгал ажил
- 12:30-13:30 Үдийн хоол
- 13:30-14:30 Цахим ертөнц дэх аюулгүй байдал
- 14:30-14:45 Цайны завсарлага
- 14:45-16:15 Цахим асуудлууд
- 16:15-16:45 Цахим орон зайтай холбоотой дасгал ажил
- 16:45-17:15 Санал бодол, үнэлгээ
- 17:15-17:30 Хаалт

Модуль 1: Хувь хүний нууцын тухай олон улсын хэм хэмжээ

Хэлэлцүүлэг: Та хувь хүний нууц гэсэн нэр томъёог сонсоод юу гэж бодож байна вэ? Түүний үндсэн шинж чанарууд нь юу вэ? Энэ нэр томъёонд зарим онцлог шинж чанар байна уу? Энэ бол хүний эрх гэж хэлвэл ямар утга агуулгатай байх вэ? Та үүнийг чухал ач холбогдолтой эрх гэж хэлж чадах уу? Яагаад тийм, эсвэл яагаад үгүй гэж?

1. Танилцуулга

- Хувь хүний нууцтай байх эрх нь нэн эрт үеэс буюу Еврей, Христос, Муслимын шашин, эртний Грек, Хятадын уламжлалаас үүдэлтэй. Олон улсад хүний эрхийн асуудал гэдэгт хувь хүний нууцын эрхийг хамааруулан авч үздэг.
- Хувь хүний нууцтай байх эрхийн үндсэн зорилго нь тухайн хүний дотоод нууцыг бусдаас чандлан хамгаалах, төрийн хөндлөнгийн оролцооноос хамгаалахад оршино. Хувь хүний нууцтай байх эрх тухайн хүний өөрийгөө илэрхийлэх эрх чөлөөний үндэс суурь болдог. Учир нь ихэнх тохиолдолд аливаа хүн үзэл бодлоо зөвхөн тухайн хэсэг бүлэг хүмүүсийн хүрээнд үлдэнэ гэсэн ойлголттойгоор илэрхийлдэг.
- Олон хүний хувьд цахим орчин дахь хувь хүний нууцын асуудал чухал ач холбогдолтойгоос гадна цахим орчинд нэвтрэхийн тулд хувийн мэдээллээ ашиглах шаардлагагүй байдгаараа биелүүлэх боломжтой. Цахим орчинд гэр бүл, орчин тойрны хүмүүс, эсхүл ажил олгогчдоо мэдэгдэлгүйгээр нууцлаг, далд хүсэл сонирхлоо илэрхийлэх боломжтой байдгаараа онцлогтой. Нэрээ нууцлах хүсэл нь зөвхөн олон нийтийн өмнө эвгүй байдалд орох, эсхүл зарим тохиолдолд нийгэмд гадуурхагдахаас өөрийгөө хамгаалах хүслээр хязгаарлагдахгүй. Тухайлбал, Уганда эсхүл ОХУ-д амьдардаг ижил хүйстнээ сонирхогч, эсвэл Саудын Арабт амьдардаг бурхангүй үзэлтний хувьд чухамдаа зөвхөн интернэтэд л өөрийгөө чөлөөтэй илэрхийлэх, ижил төстэй сонирхолтой хүмүүстэйгээ харилцах боломжтой байна.
 - Тухайлбал, нэгэн олны танил технологийн бүтээгдэхүүний цахим хэлэлцүүлгийн сайт форматаа өөрчилж, хэрэглэгчдээсээ жинхэнэ нэр, хувийн мэдээллээрээ нэвтрэх шалгуур тавьснаас үүдэн тухайн сайтад технологийн бүтээгдэхүүний талаар хатуу шүүмжлэл бичих нь илт буурч, үнэнч найдвартай чанараа алдсан байна.
 - Цахим ертөнцөд нэрээ ашиглалгүйгээр өөрийгөө илэрхийлэхийн ач тусыг Харилцаа холбооны эрх чөлөөний тухай Европын Холбооны Зөвлөлийн Тунхаг бичигт тодорхойлон тусгасан. Үүнд:

Цахим орчны хяналтаас хамгаалах, мэдээлэл, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор улс орнууд

нэр, овгоо нууцлах сонирхолтой хэрэглэгчдийн хүслийг хүндэтгэн үзэх шаардлагатай.

- Хувь хүний нууцыг хамгаалах асуудал нь өндөр ач холбогдолтой мэт боловч өнөө үед хувийн нууцтай байх эрхийн талаар дэлхий даяар олон төрлийн мэтгэлцээн өрнөж байгаа төдийгүй олон хүмүүс хувийн нууцыг орчин үед өндөр эрсдэлтэй болсон гэж үзэж байна.
- Үүний нэг шалтгаан нь интернетийн үйл ажиллагаагаа явуулдаг үндсэн бизнесийн загвар юм. Хэдийгээр Facebook, Gmail зэрэг үйлчилгээнүүд нь үнэгүй ашиглах боломжтой байдаг боловч, бодит байдал эсрэгээр байх нь олонтаа. Үнэндээ хэрэв эдгээр компани ашиггүй ажилладаг байсан бол тэд хэрхэн дэлхийн хамгийн баян арван компанийн тоонд багтах билээ? Бодит байдал дээр хэрэглэгчид эдгээр үйлчилгээнд бүртгүүлж, түүний нэгэн хэсэг болсноор хувийн нууцаа тухайн ажил, үйлчилгээг авахын төлөө арилжиж байгаа хэрэг юм. Харин тухайн компаниуд нь бидний хувийн мэдээллийг зар сурталчилгааны байгууллагууд, зарим тохиолдолд бусад компанид худалдсанаар ашиг орлого олдог байна.
 - *Жишээ нь:* Хэдэн жилийн өмнө АНУ-ын Target компани онооны картаа ашиглан хэрэглэгчдийнхээ бүтээгдэхүүн худалдан авах дадал зуршлыг судалж, нэгэн залуухан эмэгтэй үйлчлүүлэгч рүүгээ нялх хүүхдийн бүтээгдэхүүний сурталчилгааны материал илгээжээ. Тухайн эмэгтэйн эцэг сурталчилгааны материалыг үзээд Target компанид зүй бус сурталчилгааны материал ирүүлсэн гэж гомдол гаргажээ. Гэсэн хэдий ч Target компани охиныг нь жирэмсэн байсан болохыг зөв олж тогтоосон байна. Энэ тухай гомдол гаргах хүртлээ охины төрсөн эцэг ч мэдээгүй байжээ.
- Онолын хувьд, интернетийн үйл ажиллагааны бизнес загварыг хэрэглэгчид мөнгө төлдөг байхаар зохион бүтээж болох байсан. Онлайн үйлчилгээний хувьд энэ төрлийн загвараар үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд гарч ирж байгаа бөгөөд ингэснээр олон нийтийн аливаа эсэргүүцэл, мэтгэлцээнээс ангид байдаг. Зарим хүмүүсийн хувьд хувийн нууцаа хамгаалахын тулд мөнгө төлөх сонирхолтой байдаг. Өөрөөр хэлбэл, та Фэйсбүүк эсхүл Жимэйл хаягаа ашиглахын тулд мөнгө төлнө гэсэн үг юм.

Хэлэлцүүлэг: Маш олон интернэт үйлчилгээний өнөөгийн бизнесийн загварыг энэ аргаар солих нь бодитой байж болох юм гэж та бодож байна уу? Монголчууд өөрсдийн хувийн нууцаа хамгаалахын тулд эдгээр үйлчилгээг авах сонирхолтой байх болов уу?

- Үүнээс гадна Эдуард Снөүдэний төрийн хяналтын системийн талаар дэлгэсэн нууц мэдээллүүдээс үзэхэд аюул заналхийлэл зөвхөн арилжааны компаниудаас үүдэлтэй биш байна. Гэвч та өөрийгөө зөвхөн компьютер эсхүл төхөөрөмжтэйгээ л байгаа гэж бодож байгаа бол онлайн ертөнцөд энэ нь томоохон эндүүрэл болно. Снөүдэний задруулсантай ижил төстэй мэдээлэл харах бүртээ бид өөрсдийгөө улам

төрийн хяналтад орж байна хэмээн эмээдэг. Харин олон жилийн туршлагатай төрийн албан хаагчид хувь хүмүүс төрийн мэдээллийн нууцлалыг задруулж байгаа нь хууль хэрэгжүүлэх, үндэсний аюулгүй байдлыг хангах агентлагуудын цахим ертөнцийг хамгаалах чадамжийг бууруулж байна хэмээдэг.

- Хувийн компаниудын хувь хүний мэдээллийг их хэмжээгээр төвлөрүүлж байгаа нь анхаарал татахуйц асуудал боловч интернэтийн дата цуглуулах механизм нь улсын гарт байх нь илүү хор уршигтай санагдана. Учир нь улс хувийн компаниудаас ч илүү тухайн хувь хүний дээгүүр эрх мэдэлтэй байна.
- Цаашлаад шүүх болон хууль хяналтын байгууллагууд төрийн байгууллагууд төдийгүй үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудалд илүү өнөр ач холбогдол өгч хандах, хувь хүний нууцын тухай хуулийг чандлан сахиулах асуудалд хувийн компаниудаас илүү тусгайлан эрх олгосон байдалтайгаар уян хатан хандах нь элбэг. Түүнчлэн хувийн компаниудын хувьд нээлттэй зах зээлд үйл ажиллагаа явуулдаг тул мэдээллийн хэт түрэмгий байдлаас зайлсхийдэг. Учир нь тухайн компани хэрэглэгчийн зан төлвийн цахим судалгааг хэтрүүлэн хэрэглэх тохиолдолд бизнесийн ашгаа алдахад хүрэх эрсдэлтэй. Гэвч төрийн хууль сахиулах байгууллагуудад энэ төрлийн эрсдэл, айдас байхгүй. Хэрэглэгчид хувийн нууц хадгалах бодлого, зааврыг уншиж ойлгох чадвар дутмаг байдгаас хяналт хэрэгжүүлэх чадвар нь хязгаарлагдмал байдаг. Үүнээс шалтгаалан тухайн бодлого, зааварт хувь хүний эрхэд халдсан шинж чанартай заалтууд орох, энэ нь цаашлаад хэрэглэгчийн өгөгдлийн санд нөлөөлөх эрсдэлтэй. Гэвч болзошгүй санхүүгийн эрсдэл нь тухайн компанийг хэт түрэмгий зан төлөв гаргахаас сэргийлдэг.

2. Хувь хүний нууцын эрх зүйн тодорхойлолт

- Хувийн нууцын халдашгүй байдлыг Олон улсын хуулиар хэлбэрийн хувьд болон эрх зүйн хувьд хамгаалдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын *12 дугаар зүйлд*:

Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн оролцох, орон байрны халдашгүй байдал, захидал харилцааных нь нууц болон нэр төр, алдар хүндэд нь халдах ёсгүй. Тийм оролцоо халдлагын эсрэг хэн ч бай хуулиар хамгаалуулах эрхтэй.

- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 17 дугаар зүйлд:

1. Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.

2. Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.

- Энэ хоёр тодорхойлолт нь хоорондоо ижил хэдий ч, зарим чухал ялгаа бий. Хүний эрхийн түгээмэл тунхаглалаар зөвхөн хувийн нууцын халдашгүй байдалд хөндлөнгөөс дур мэдэн нөлөөлж оролцохыг хориглосон хэдий ч, хууль бусаар гэдэг нь байхгүй юм. Бодит байдалд, хууль бус хөндлөнгийн оролцоо нь ямагт дур зоргын болохыг нь тодруулдаг учраас энэхүү хязгаарлалт нь ач холбогдолтой юм. Мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар нэр төр, алдар хүндэд зөвхөн хууль бусаар халдахаас хамгаалсан бол, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд бүхий л төрлийн халдлагаас хамгаалагдах тухай заасан. Хэдийгээр хууль зүйн хувьд өмнө нь туршигдаагүй байгаа хэдий ч, энэ нь утга агуулгын хувьд ач холбогдолтой байж болох юм.

Хэлэлцүүлэг: Хувь хүний нууцын эрх зүйн тодорхойлолт дахь гол бүрэлдэхүүн хэсгүүд нь юу байх ёстой гэж та бодож байна вэ? Эсвэл та энэ бол зүгээр л хэтэрхий хийсвэр, эсвэл янз бүрээр тодорхойлогдож болно гэж бодож байна уу?

- Эдгээрээс гадна хувь хүний нууцтай байх эрхийн бүрэн агуулгыг тодорхойлох нь бэрхшээлтэй. Ямартаа ч хувь хүн мэдээллээ гадны аливаа халдлагаас ангид байлгах, хамгаалуулах эрхтэй боловч үүнээс цаашлаад судлаачид тус ойлголтыг харилцан адилгүй тодорхойлж байна.
 - *Жишээ нь:* Энэ сэдвээр Уоррен болон Брандэй нар “Хувийн нууцтай байх эрх” номондоо “хувь хүний нууц гэдэг нь хүний тусгаар байх эрхийг хэлнэ” гэжээ. Walmart компанийн эсрэг, Лейкийн маргааныг (1998) шийдвэрлэхдээ Миннесота мужийн дээд шүүхээс хувь хүний нууцтай байх дөрвөн төрлийн сонирхлыг тодорхойлсон. Үүнд: бусдын тусгаарлагдсан орон зайд учир шалтгаангүйгээр халдах, бусдын нэр төр эсхүл мөн чанарыг ашиглах, аливаа хүнийг буруу ойлголт төрүүлэхээр олон нийтэд таниулан сурталчлах, хувь хүний амьдралыг тодорхой шалтгаангүйгээр нийтэд ил болгох зэрэг болно. Смит нарын эсрэг, НМ нарын маргааныг (2007 он) шийдвэрлэхдээ Өмнөд Африкийн Үндсэн хуулийн цэц хувийн нууцыг “аливаа хүн амьдралаа хүссэнээрээ жолоодох эрх” хэмээн шинэчлэн тодорхойлжээ. Канадын дээд шүүх Лоонгийл хотын захиргааны эсрэг, Гобөүтийн маргааныг (2007 он) шийдвэрлэхдээ хувийн нууцыг “хувь хүн дотоод сонголтоо хийдэг хувийн бие даасан орон зай” хэмээн тодорхойлсон байдаг.
 - *Жишээ нь:* Европын Холбооны Хүний эрхийн шүүхийн хувьд тус ойлголтыг тодорхойлохоос зайлсхийж, “Шүүхээс ‘хувь хүний амьдрал’ гэдэг ойлголтыг тодорхойлох боломжгүй буюу шаардлагагүй” гэж үзсэн байна (Герман Улсын эсрэг, Гобөүтийн маргаан, 1992 он). Гэсэн хэдий ч тус шүүхээс хувийн эрх зөрчигдөж болохуйц тохиолдлуудыг

тодорхойлсон. Үүнд, тухайлбал, харилцаа холбооны агуулгаас нь үл хамааран хувийн харилцаа холбоонд хөндлөнгөөс оролцох, утасны яриа чагнах¹, хүүхдийн эрх², хувь хүний бэлгийн амьдрал³, зайлшгүй эмнэлгийн үйлчилгээ⁴, улсын бүртгэлийн мэдээлэл зэрэгт хөндлөнгөөс оролцох⁵ зэргийг хувь хүний нууцтай байх эрхийг зөрчсөн үйлдэл гэж тодорхойлсон.

- Европын Холбооны шүүхээс хувь хүний нууцын эрхийн хэд хэдэн шинж чанарыг тодорхойлсон. Герман Улсын Вон Ханноверийн гэх хэргийг шүүхээс “хувь хүний нэр, зураг зэрэг хувийн мэдээлэл”, мөн “хувь хүний бие, сэтгэхүйн халдашгүй байдал”-ыг хувь хүний нууцад хамаарна хэмээн хянан шийдвэрлэсэн байна. Түүнчлэн хувь хүний нууцын эрхийн үндсэн зорилго нь “хөндлөнгийн оролцоогүйгээр тухайн хүний бусад хүмүүстэй харилцах зан чанарыг хөгжүүлэх”-эд оршино⁶. Герман Улсын Ниймецийн гэх хэргийн мөрөөр “хувь хүний нууцтай байх эрх гэдгийг зөвхөн тухайн хүний өөрийн нь сонгосон амьдралын ‘дотоод тойрог’ дотор хязгаарлаж ойлгоод гадаад ертөнцийг тусгаарлан авч үзэх нь дутмаг” байна. Харин “хувийн амьдрал гэдэгт бусад хүмүүстэй харилцаа үүсгэж, хөгжүүлэх эрх тодорхой түвшинд багтана”.⁷ Бизнесийн болон мэргэжлийн харилцаа нь мөн тус ойлголтод тодорхой хүрээнд хамрагдана. Ингэснээр бизнесийн орчинд хөндлөнгөөс оролцох нь тодорхой түвшинд хувь хүний амьдралд оролцож байна гэж ойлгогдоно.⁸
- Иймд шүүхээс “тухайн хувь хүний нууцын тухай ойлголт нь чухал байж болох ч энэ нь эцсийн шийдвэрлэх хүчин зүйл биш” гэж шийдвэрлэжээ.⁹ Зарим тохиолдолд олон нийтийн газраас цуглуулсан мэдээлэл нь хувь хүний нууцтай холбогдож болох юм. Иймд “Нийтийн домэйн хуудсанд буй аливаа системтэй, байнгын мэдээлэл нь хувийн амьдралтай холбоотой асуудлуудыг хөндөх боломжтой”.¹⁰

Хэлэлцүүлэг: Тодорхойлолтууд нь агуулгын хувьд хэт өргөн байна уу, эсхүл тэдгээртэй санаа нийлж байна уу?

¹ Үз, жишээ нь, *Iordachi And Others v. Moldova*, 2009 оны 2 сарын 10, Өргөдөл No. 25198/02. Үз мөн *Halford v. the United Kingdom*, 1997 оны 6 сарын 25, Өргөдөл No. 20605/92, пара. 44.

² Үз, жишээ нь, *Elsholz v. Germany*, 2000 оны 7 сарын 13, Өргөдөл No. 25735/94.

³ Үз, жишээ нь, *Dudgeon v. the United Kingdom*, 1981 оны 10 сарын 22, Өргөдөл No. 7525/76. Үз мөн *Mosley v. Их Британи*, 2011 оны 5 сарын 10, Өргөдөл No. 48009/08.

⁴ Үз, жишээ нь, *Acmanne and others v. Belgium*, 1984 оны 12 сарын 10, Зөвшөөрсөн шийдвэр, Өргөдөл No. 10435/83.

⁵ Үз, жишээ нь, *Gaskin v. Их Британи*, тэмдэглэл 13.

⁶ 2004 оны 6 сарын 24, Өргөдөл No. 59320/00, пара. 50. Бусад хэргийн солбицсон эшлэл эндээс хасагдсан.

⁷ 1992 оны 12 сарын 16, Өргөдөл No. 13710/88, пара. 29.

⁸ Үз мөн *Von Hannover v. Germany (No. 2)*, 2012 оны 2 сарын 7, Өргөдөл No. 40660/08 ба 60641/08, пара. 95.

⁹ *P.G. AND J.H. v. Их Британи*, 2001 оны 9 сарын 25, Өргөдөл No. 44787/98, пара. 57.

¹⁰ Мөн тэнд. Жишээ нь, аюулгүйн үйлчилгээний нээлттэй цуглуулсан мэдээллийг сурвалжилж болно. Үз *Rotaru v. Romania*, 2000 оны 5 сарын 4, Өргөдөл No. 28341/95.

- Ерөнхийдөө хувь хүний нууцтай байх эрх нь тухайн хүний нууцлах хүсэл сонирхлын түвшинг хүртэл хамарна. Энэхүү түвшин нь зан заншил, соёлын ялгаа, хугацаанаас хамааран харилцан адилгүй байх тул нарийвчлан тодорхойлоход хүндрэлтэй. Гэвч энэхүү сорил нь цаг хугацаа болон соёлын ялгаанаас үл хамааран тогтвортой байна.
- Хувь хүний нууцыг бусдад гэрээний үндсэн дээр задруулж болдгоороо бусад төрлийн хүний эрхээс ялгаатай байна. Тухайн хүн өөрийн хүсэлтээр гуравдагч этгээдэд тодорхой зорилгоор хувийн нууцдаа нэвтрэх буюу зарим тохиолдолд олон нийтэд ил болгох эрх олгодгоороо онцлогтой.
- Түүнчлэн хувь хүний нууцын агуулга субъектив шинж чанартай байна. Тухайлбал, зарим нэг хувийн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэл мэтээр хандвал хувийн мэдээллийн тодорхой хэсэг нь хувийн нууцад хамаарахаа болино. Жишээ нь, хүний гэрлэсэн эсэх тухай мэдээлэл нь хичнээн хувь хүний нууцад хамаарах боловч, хэрэв тус мэдээллийг олон нийтэд тогтмол цацвал хувийн мэдээлэл биш болно. Өөрөөр хэлбэл, тухайн хүн хувийн мэдээллээ ашиглах, түүнд нэвтрэх эрхийг олон нийтэд олгож байна гэсэн үг юм. Үүнийг хүний нэр хүнд, үг хэлэх эрх чөлөө зэрэг илүү тод тодруун, объектив шинж чанар бүхий хувь хүний эрхүүдтэй харьцуулан авч үзэх боломжтой.
- Хүний бүхий л эрхүүд нь улс орнуудыг нэгтгэдэг. Олон улсын хууль тогтоомжид аливаа улсыг хувийн нууцаар оролдохгүй байхыг тодорхой заадаг. Олон улсын шүүхээс гаргасан олон шийдвэрүүдээс энэхүү хандлага түгээмэл ажиглагдана. Европын шүүхээс “8 дугаар зүйлийн объект нь “үндсэндээ” хувь хүнийг төрийн байгууллагуудын нэг талын хөндлөнгийн оролцооноос хамгаалахад оршино” гэжээ.¹¹
- Эдгээр шийдвэр гаргах үндсэн шалтгаан нь утасны яриа чагнах болон бусад төрлийн холбооны хэрэгсэлд цагдан хяналт тогтоох гэх мэтчилэн цагдаагийн хяналттай холбоотой байна. Өөрөөр хэлбэл, хууль хяналтын эрх мэдлийг хэтрүүлэн ашиглахаас хамгаалах үндсэн зорилготойгоос гадна иргэнийхээ хувийн нууцыг чандлан хамгаалах улс орны үүргийг онцолдог.
 - *Жишээ нь:* Европын шүүхээс хувь хүний нууцтай байх сонирхол нь тухайн улс орны хувь хүний нууцыг чандлан хамгаалах үүргээ хэрэгжүүлэх үйлдэхүйгээр илэрхийлэгдэнэ гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, тухайн улс орон өөрөө хүний нууцад хөндлөнгөөс оролцож зөрчөөгүй ч, хэрэв тухайн улсын иргэний хувийн нууц задрахад хүрвэл тухайн улс орон иргэнийхээ нууцыг хамгаалах үүргээ хэрэгжүүлж чадаагүй гэж үздэг байна.¹² Зарим тохиолдолд хувь хүн болон улс хоорондын харилцаа, эсхүл эрхээ эдлэх “босоо” тэнхлэгт хамаарна. Англи Улсын Гаскины гэх хэрэг нь үүний нэг жишээ юм. Энэ кейс тохиолдолд, шүүхээс төрийн байгууллагыг тухайн хүний хувийн

¹¹ Үз *Marckx v. Belgium*, 1979 оны 6 сарын 13, Өргөдөл No. 6833/74, пара. 31.

¹² *Airey v. Ireland*, 1979 оны 10 сарын 9, Өргөдөл No. 6289/73, пара. 37.

сонирхлыг хамгаалахын тулд хувийн мэдээллийг нь гаргаж өгөх үүрэгтэй байсан гэж үзжээ.¹³

- Хувь хүний нууцтай байх эрх нь хувь хүнийг төрийн хөндлөнгийн оролцооноос хамгаалдаг боловч олон улсын хуулийн дагуу тус хувийн нууцтай байх эрх нь мөн “хэвтээ” тэнхлэгийн харилцаанд давхар хамаардаг. Энэ нь улсын хүлээх үүрэг хариуцлагын бас нэгэн хэлбэр юм. Энэ тохиолдолд, улс болон хувь хүний харилцаа бус, харин тухайн улсын үйлдэхүй болон эс үйлдэхүйг хэлнэ. Учир нь хувийн амьдралыг хамгаалахын тулд төр бусад төрийн бус хуулийн этгээд, хувь хүмүүс хоорондын харилцааг зохицуулах шаардлагатай болно. Үүнд, хувь хүний нууцад халдахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн байх ёстой.
 - *Жишээ нь:* НҮБ-ын Хүний эрхийн хорооны 17 дугаар зүйл хийсэн 1988 оны 16 дугаар Ерөнхий тайлбартаа хувийн нууцтай байх эрх гэдэгт “төрийн байгууллага, хувь хүн эсхүл хуулийн этгээдээс гарч болохуйц аливаа хөндлөнгийн оролцоо, дайралтаас хамгаалуулах эрх”-ийг хамруулан авч үзнэ гэжээ.

Хэлэлцүүлэг: Улс орнууд бусад хувийн оролцогч талуудын болзошгүй дайралтаас хувь хүний нууцыг хамгаалах шаардлагатай тулгарсан зарим нэг жишээг дурдаж чадах уу?

- Европын Хүний эрхийн шүүх дээр ирсэн зарим хэрэг маргаанууд нь улс үүргээ биелүүлж чадаагүйтэй холбоотой байсан.
 - Испани улсын Липез Острагийн гэх хэргийг шүүхээс төрийн байгууллага цэвэрлэх байгууламжаас гарч буй хаягдлаас байгаль орчныг хамгаалж чадалгүй бохирдуулж байгааг 8 дугаар зүйлийг зөрчсөн хэмээн шийдвэрлэсэн байна. Ингэхдээ шүүхээс тухайн цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн үндэслэл нь Испанийн дотоодын хууль тогтоомжид үл нийцэж байгаа зэргээс үүдэн Испани улс хатагтай Липез Остраг хамгаалах үүргээ биелүүлж чадахгүй байгаад зогсохгүй асуудлыг сунжруулахад хувь нэмэр оруулсан гэж үзжээ.¹⁴ Нидерланд улсын¹⁵ эсрэг маргааныг шүүхээс шийдвэрлэхдээ хувь хүнийг бэлгийн хүчирхийллээс хамгаалах иргэний болон эрүүгийн хуулийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй гэж үзсэн байна. Тухайн үед Нидерланд улс бэлгийн хүчирхийллийн хэрэгтнүүдэд эрүүгийн хэрэг үүсгэх хатуу зохицуулалтгүй байсан бөгөөд Нидерланд улсын хуулийн дагуу тухайн тохиолдолд хүчирхийллийн золиос нь оюуны бэрхшээлтэй иргэн байсан тул гэмт хэрэг гарсныг нотлох чадамжгүй гэж үзсэн байна.

¹³ *Gaskin v. Их Британи*, 1989 оны 7 сарын 7, Өргөдөл No. 10454/83, пара. 41 and 49.

¹⁴ 1994 оны 12 сарын 9, Өргөдөл No. 16798/90, пара. 54-6.

¹⁵ 1985 оны 3 сарын 26, Өргөдөл No. 8978/80.

3. Хувийн нууцын хязгаарлалт

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний нэгэн адил хувь хүний нууцтай байх эрх нь абсолют мөн чанартай биш боловч, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй харьцуулахад хил хязгаар нь тодорхой бус байна.
- НҮБ-ын Хүний эрхийн комиссын 16 дугаар тайлбарт “нэг талын хөндлөнгийн оролцоо” гэдгийг хувийн нууцтай хэрхэн холбогдох талаар тодорхойлон заагаагүй байна. Хүний эрхийн зөвлөлөөс хуулиар эрх олгосон хөндлөнгийн оролцоог нэг талын оролцоо хэмээн авч үзэж болох бөгөөд энэ төрлийн бүх хөндлөнгийн оролцоо нь “Хэлэлцээрийн зорилго, зорилт, заалтуудад нийцэх ёстой бөгөөд ямар ч тохиолдолд хүндэтгэлтэй байх ёстой”. Тус тайлбар нь хувь хүний нууцад хөндлөнгөөс оролцохтой холбоотой өмнө нь хуулиар зөвшөөрөгддөг байсан боловч, Хэлэлцээрийн зүйл заалтад үл нийцсэн асуудлуудыг хязгаарласнаараа давуу талтай боловч, “нэг талын оролцоотой” гэдэг ойлголтын хамрах хүрээг нарийвчлан тайлбарлаагүй байна. Зөвлөлийн тус тайлбар дахь хууль эрх зүйн тогтолцоо нарийн тодорхой бус байв.
- Бодит байдал дээр онлайн орчин дахь хувийн нууцын асуудал нь иргэний болон эрүүгийн эрх зүйн аль алинд хамааралтай. Эрүүгийн эрх зүйн хувьд төрийн байгууллагууд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, цахим гэмт хэргийг таслан зогсоох, тухайлбал, насанд хүрээгүй хүүхдийн порнографийг хориглох гэх мэтээр тодорхой түвшинд хяналт хэрэгжүүлэх боломжтой байна. Гол нь үүний хамрах хүрээ аль хүртэл үргэлжлэх вэ, аль цэгээс эхлээд энэ нь хүний эрхэд халдаж эхлэх вэ гэдэгт оршино.
- Иргэний эрх зүйн хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь хувийн нууцыг хязгаарладаг бөгөөд онлайн орчин дахь хувийн нууцлалыг ил болгосноор тухайн хүний нэр хүнд, оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлага тулгарч болох юм.
- Гэрээний нууцад халдах асуудал нь интернет орчинд үзүүлж буй үйлчилгээний үндсэн хэсгийг дэмжин ажилладаг бизнесийг загварт хөтлөгддөг. Google бас Facebook зэрэг онлайн орчинд “үнэгүй” үйлчилгээ үзүүлдэг компаниудын хувьд орлогын дийлэнх хэсгээ зар сурталчилгаа, хэрэглэгчийн мэдээллийг худалдаалснаар олдог. Өөрөөр хэлбэл, тэдгээр вэбсайтын хэрэглэгчид тухайн үйлчилгээг авахын тулд мөнгө төлөхийн оронд тэдгээр үндсэндээ хувийн мэдээллээрээ төлбөр гүйцэтгэж байна гэсэн үг юм. Хэдийгээр онолын хувьд бүх хүнд энэ төрлийн үйлчилгээг хэрэглэх эсэх тухайгаа өөрөө шийдэх эрх байгаа мэт боловч, бодит байдал дээр орчин үед амьд явахын тулд онлайн үйлчилгээ үзүүлэгчдэд ихээхэн хэмжээний хувийн мэдээллээ өгч золиослохоос өөр аргагүйд хүрч байна.
- Үндсэн асуудал нь бид хэрхэн эдгээр онлайн үйлчилгээг авах шийдвэр гаргаж байгаагаас шалтгаалан тухайн хүний хүсэл, сонголт гэсэн ойлголт хүчгүй сул дорой болж байгаа юм. Тухайн хүний хүсэл, сонголт гэдэг нь үндсэндээ тухайн хүн юуг хүлээн авч, зөвшөөрч байгаага мэдэж байгаа гэсэн үг боловч өнөөдөр хэд хэчнээн хүн үнэндээ онлайн үйлчилгээний нөхцөл, шалгуурыг хүлээж авахаасаа өмнө нарийн уншиж танилцдаг

билээ? Хэрэглэгчдийг тэдгээртэй уншиж танилцана гэж бодох нь хэр бодит байдалд нийцэх вэ? Үйлчилгээний нөхцөл, шалгуур нь ихэвчлэн маш урт, ойлгоход ярвигтай байдаг.

Хэлэлцүүлэг: Энэ нь орчин үеийн дэлхий дахинд хамгийн том мэтгэлцээнийг өрнүүлж байна. Та энэ асуудлыг шийдвэрлэх арга замуудын талаар бодож чадах уу? Интернэт үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааны (ихэвчлэн хууль зүйн) хэрэгцээг хэрхэн хүндэтгэж, мөн ямар зөвшөөрөл олгосноор арга замыг бэхжүүлэх вэ?

- Европын Хүний эрхийн шүүхээс 8 дугаар зүйлийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын нэр томъёоноос ялгаатай байдлаар нарийвчлан томъёолсон байна. Үүнд:

(1) Хүн бүр өөрийн хувийн болон гэр бүлийн амьдрал, түүний орон гэр болон түүний захидал харилцааг хүндэтгэх эрхтэй.

(2) Энэхүү эрхээ эдлэхэд нь зөвхөн хуулиар тогтоосон бөгөөд нийтийн эмх замбараагүй байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсвэл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд үндэсний аюулгүй байдал, нийгмийн аюулгүй байдал, улс орны эдийн засгийн сайн сайхан байдлын ашиг сонирхлын үүднээс ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд төрийн эрх бүхий байгууллагаас ямар ч хөндлөнгийн оролцоо байх ёсгүй.

- Иймд эрх гэдэг ойлголтыг хувийн нууцаа хөндлөнгийн оролцооноос хамгаалуулах гэхээс илүүтэй бусдын хувийн нууцыг хадгалах гэсэн утгаар тун эергээр тайлбарласан байна. Нөгөө талаас Европын Холбооны Хүний эрхийн шүүхээс заалтыг хязгаарласан байдлаар тайлбарлаагүй ч, хамгаалалт нь төрийн байгууллагуудын хөндлөнгийн оролцоогоор хязгаарлагддаг байна. Эцэст нь, хориг, хязгаар тавих стандартыг маш тодорхой маягаар илэрхийлсэн. “Нэг талын оролцоотой”, “хууль бус”, “гутаан доромжилсон” зэрэг ерөнхий ойлголтуудыг ашиглахын оронд гурван хэсэг бүхий шалгуур байна. Үүнд: а) хуулийн дагуу; б) ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай; с) жагсаалтад багтсан сонирхлуудын аль нэгийг хамгаалах (үндэсний аюулгүй байдал, нийтийн эмх замбарааг хадгалах гэх мэт).

Хэлэлцүүлэг: Европын тодорхойлолтыг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын заалттай харьцуулахад ямар байна вэ? Өмнөх тодорхойлолт нь хэт өргөн бас хүчтэй утга агуулгатай байх болов уу?

- Шүүхээс хувийн нууцад хөндлөнгөөс оролцохтой холбогдуулан гурван талт шалгуур үзүүлэлтийг хэрэгжүүлэх нарийвчилсан арга зүйг боловсруулжээ. Хэд хэдэн тохиолдолд, ялангуяа утасны яриа чагнах буюу энэ төрлийн арга барил нь хувийн нууцад хэт хөндлөнгөөс

оролцсон шинж чанартай байх тул тэдгээрийг хэрэгжүүлэхдээ “маш тодорхой зохицуулалт бүхий “хууль”-ийг үндэслэл болгоно... учир нь энэ төрлийн технологи улам хурдацтай хөгжиж байгаа билээ”.¹⁶ *Франц улсын Крузлин* гэх хэргийн тухайд шүүхээс утасны яриа чагнах нөхцлийг хангалттай нарийвчлан тодорхойлоогүй байсан тул шалгуурт нийцээгүй гэж үзсэн байна. Илүү дэлгэрүүлэн авч үзвэл, утасныхаа яриаг чагнуулах өндөр магадлал бүхий иргэдийг тодорхойлон ангилж ялгасан зүйл байхгүй, шүүгчдэд яриа чагнах хугацааг хязгаарлах ямар ч үүрэг хариуцлага байхгүй, тухайн хөндлөнгөөс сонссон ярианы бичлэг, тайланг хэрхэн гаргах талаар эсхүл тэдгээр бичлэг, тайланг хэрхэн устгах талаар ямар ч тогтсон арга аргачлал байхгүй, мөн тэдгээр бичлэгийг гадны оролцооноос хамгаална гэсэн ямар шаардлага тусгагдаагүй байна.¹⁷

- *Нэгдсэн вант улсын Малөүний* гэх хэргийн тухайд Европын Холбооны шүүх утасны дуудлагыг “хэмжих” (энэ нь залгасан дугаар ба дуудлагын хугацааг бүртгэхийг хэлнэ) үйл ажиллагааг нарийвчлан авч үзсэн байна. Энэ нь шууд яриаг чагнадаггүйгээрээ ялгаатай, тухайн хэрэглэгч төлбөрийн мэдээллээ шалгах зэрэг тохиолдолд хуулийн дагуу авч болдог мэдээлэл хэдий ч энэ мэдээллийг цагдаагийн байгууллагад дамжуулна гэдэг нь тухайн хүний хувийн амьдралд оролцсон хэрэг болно. Утасны дуудлага хэмжих үйлчилгээг үзүүлдэг Үндэсний шуудан компанийг (тухайн маргаан үүсэх үед тус компани нь төрийн өмчит Британийн харилцаа холбооны газар болсон байсан) энэ төрлийн мэдээллийг цагдаад өгөхийг үүрэг болгосон аливаа хууль эрх зүйн зохицуулалт байхгүй байсан. Гэсэн хэдий ч бодит байдалд тухайн байгууллага нь “онц ноцтой гэмт хэрэгтэй холбогдуулан, өөр бусад эх сурвалжаас олж авах боломжгүй тохиолдолд цагдаагийн байгууллагаас хүсэлтээр” мэдээллийг гаргаж өгдөг байсан. Энэхүү байдал нь Европын Холбооны Хүний эрхийн комиссын 8 дугаар зүйлийн 2-т заасан “хууль эрх зүйн зохицуулалтын дагуу” гэсэн шаардлагад нийцэхгүй байгаа юм.¹⁸ Тус дадал хэвшил нь цаашлаад интернэт үйлчилгээ үзүүлэгч хувийн компаниудад мөн адилхан давтагдаж байгаагаар хувийн нууцын эрхэд халдаж байна.
- Шалгуурын хоёрдугаар шалгуур үзүүлэлтийн хувьд шүүх ерөнхийдөө олон нийтийн амгалан тайван байдлыг хадгалах зорилгоор хувийн нууцыг задруулахаас аргагүйд хүрч байгааг хүлээн зөвшөөрөхөд асуудалгүй байна. Харин *Швед улсын Леандерийн* хэргийн хувьд шүүхээс тухайн ажлын байранд шинээр ажилтан шалгаруулж авахдаа цуглуулсан материалыг цагдаагийн байгууллагад өгөх нь үндэсний аюулгүй байдалд хамаарна¹⁹ гэж үзсэн тухай нэг параграф нэг богино дүгнэлт гаргасан бол, *Нэгдсэн вант улсын Муррэйгийн* хэрэгт шүүх гэмт

¹⁶ Үз, жишээ нь, *Kruslin v. France*, 1990 оны 4 сарын 24, Өргөдөл No. 11801/85, пара. 33. Мөн үз *Rotaru v. Romania*, note, пара. 62. Сүүлийн хэрэг хувь хүний өгөгдлийг цуглуулах ажиллагаатай холбоотой.

¹⁷ Мөн тэнд., *Kruslin v. France*, пара. 35.

¹⁸ *Malone v. United Kingdom*, 1984 оны 8 сарын 2, Өргөдөл No. 8691/79, пара. 83-86.

¹⁹ 1987 оны 3 сарын 26, Өргөдөл No. 9248/81, пара. 49.

хэргээс урьдчилан сэргийлэхийг хууль эрх зүйн үндэслэл бүхий шалтгаан гэж үзсэн тухай нэг параграф дүгнэлт гаргажээ.²⁰

- Шалгуурын гуравдугаар шалгуур үзүүлэлтийн дагуу хянаж үзээд шүүхээс “хувь хүний сонирхол болон олон нийтийн эрх ашгийг бүхэлд нь авч үзэн, тэдгээрийг тэнцвэртэй байр сууринаас авч үзэх ёстой” гэжээ.²¹ Түүнчлэн, “зайлшгүй шаардлагатай байна гэдэг нь хөндлөнгийн оролцоо нь нийгэмд тулгамдсан хэрэгцээ, үндсэн зорилгод нийцэхүйц, мөн хөндлөнгөөс оролцох шалтгаан нь “хамаарахуйц, хангалттай байх” ёстой” гэжээ.²² Үндэсний шүүхийн нэгэн адил Европын шүүх нь хувийн нууцыг хязгаарлах, нэн ялангуяа хүний эрхтэй холбоотой асуудлаар олон нийтийн сонирхлыг нэн тэргүүнд тавьсаар ирсэн.

Хэлэлцүүлэг: Хувийн эсвэл нийтийн ашиг сонирхолыг тэнцвэржүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл. Анхааралдаа авч үзэх шаардлагатай зарим ямар хүчин зүйл байна гэж та бодож байна вэ? Тэдгээрийг тэнцвэржүүлэх зарим нэг арга замыг баталгаажуулахдаа нь шударга байна гэж үзэж байна уу?

Ном зүй

1. Уоррен болон Брандэй нар, “Хувийн нууцтай байх эрх” (1890 он) 4 Харвардын Хуулийн тогтмол сэтгүүл 193 дугаар
2. НҮБ-ын Хүний эрхийн хорооны 1988 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 16 дугаар Ерөнхий тайлбар, Хувийн, гэр бүлийн, орон байранд буюу захидал харилцааных нь нууцыг хүндэтгэх, нэр төр, алдар хүндийг хамгаалах тухай (17 дугаар зүйл)
3. Эндрю Пуддэфэтт, Тоби Мендел, Бен Вагнер, Диксий Хаутин болон Наталья Топпес, *Интернэт дэх хувь хүний нууц ба Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын судалгаа* (2012 он, Парис, ЮНЕСКО). Дэлгэрэнгүйг: unesdoc.unesco.org/images/0021/002182/218273e.pdf.

²⁰ 1994 оны 10 сарын 28, Өргөдөл No. 14310/88, пара. 89.

²¹ *Keegan v. Ireland*, 1994 оны 5 сарын 26, Өргөдөл No. 16969/90, пара. 49.

²² *Olsson v. Sweden*, 1988 оны 3 сарын 24, Өргөдөл No. 10465/83, пара. 67-68.

Модуль 2: Хувь хүний нууц ба үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө

Хэлэлцүүлэг: Та үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хувь хүний нууцын харилцан үйлчлэлийн гол арга замуудыг юу гэж бодож байна вэ? Энэхүү харилцаа хамаарлын зарим нэг эерэг талыг та юу гэж бодож байна вэ? Эдгээр эрх нь хоорондоо зөрчилдөөнт байдалд орох хүрээ нь юу байх вэ? Ийм зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэх боломжтой вэ?

- Хувь хүний нууцтай байх эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь цогц байдлаар өөр хоорондоо харилцан уялдаа хамааралтай юм. Олонх тохиолдолд, хувь хүний нууцтай байх эрхийг хүндэтгэх нь бусад ардчилсан эрхийн адил үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмждэг. Тодорхой жишээ дурдвал, харилцаа холбоонд хувь хүний нууцыг хүндэтгэх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэх урьдчилсан нөхцөл болж, эргээд харилцаа холбооны үйл ажиллагаанд оролцож буй этгээдүүдэд итгэл найдварыг бий болгох нөхцөлийг бүрдүүлдэг.
- Үзэл бодолтой байх, түүнээ илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч 2013 оны тайландаа хувь хүний нууцтай байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хоёрын хоорондох эерэг уялдаа холбоог дараах байдлаар цохон тэмдэглэсэн байна:
 - Улс орнууд хувь хүний нууцтай байх эрхийг хүндэтгэн, хамгаалж, хөхиүлэн дэмжихгүйгээр хувь хүний мэдээлэл чөлөөтэй хайх, олж авах, түүнийгээ илэрхийлэх эрхийг баталгаажуулж чадахгүй юм.... Хувь хүний нууцтай байх, аюулгүй байдал, харилцаа холбоонд нэрээ нууцлах эрхийг хангахуйц хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ байхгүй тохиолдолд сэтгүүлчид, хүний эрхийг хамгаалагчид, шүгэл үлээгчид, тодруулбал, тэд өөрсдийн харилцаа холбоогоо улс орны засгийн газрын нарийн хараа хяналтанд орохгүй гэдэгт итгэлтэй байж чадахгүй байна.
- Нөгөө тохиолдолд, хувь хүний нууцыг хүндэтгэх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөтэй зөрчилдсөн байлаа ч, тухайлбал, тэргүүлэх улс төрчийн тухай хувийн нууц мэдээллийг дэлгэрэнгүйгээр нийтлэхийг сонины газар зорьж болно. Магадгүй уг сонины газар энэ мэдээлэл нь олон нийтийн ашиг сонирхолд нийцнэ гэж итгэж байж болох юм. Ийм жишээ сонинд өдөр тутам тохиолдож байдаг.
- Эдгээр харилцаа хамаарал нь уламжлалт болон интернэт орчны шинэ аргын аль алианаар нь илэрдэг. Үнэн хэрэгтээ, эдгээр асуудлууд нь интернэт болон бусад дижитал харилцаа холбооны систем (тухайлбал, гар утас гэх мэт)-ээр үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд авчирсан их хэмжээний өөрчлөлт нь хол илүү тайтгарлыг авчирдаг. Жишээлбэл, харилцаа холбоогоор дамжуулж буй хувь хүний үйл ажиллагааг төрөөс хянах эрх мэдэл нь цахим систем идэвхжүүлэх гэсэн мэдээлэл уул уурхайн нөөцийн их хэмжээний өсөлтийн дагуу квант зэрэг өссөн байна.

1. Эерэг хүчин зүйл

- Хэдийгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь олны танил оддын тухай хувийн мэдээллийг олон нийтэд ил болгосон учраас бие биенийхээ эсрэг сөргүүлэгдэн тавигдах үед үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хувь хүний нууцын талаарх хамгийн их маргаант асуудлууд байнга үүсдэг ч, үнэндээ дээрх хоёр эрх нь бие биеэ харилцан дэмжиж байдаг.

Хэлэлцүүлэг: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэн баталгаажуулахын тул хувийн нууцад нэвтрэх зарим ямар арга байна гэж бодож байна вэ?

- Ихэнх тохиолдолд, ялангуяа утасны яриа чагнах болон мөрдөн тагнах бусад хэлбэрүүд нь аль аль эрхийн хувьд халдлагад өртөж буй явдал юм.
 - Жишээ нь: БНХАУ-ын сэтгүүлч Ши Тао 1989 оны Тяньаньмэний талбай дээрх эсэргүүцлийн жагсаалын ойн талаарх сурвалжлагадаа Хятадын засгийн газрын бодлогыг хэлэлцсэн и-мэйл явуулсныхаа төлөө 2005 онд 10 жилийн хорих ялаар шийтгэгдсэн. БНХАУ-ын Засгийн газрын хүсэлтээр Yahoo! Компани Тао-гийн Yahoo! и-мэйл хаягнаас имэйлүүдийг нь гаргаж өгсөн юм. Ийнхүү өгсөн и-мэйлд үндэслэн Тао-г төрийн нууц задруулсан гэж ялласан байдаг.
- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувь хүний нууцын аль аль нь халдлагад өртсөн үед Олон улсын шүүхээс эдгээр хөндлөнгийн оролцоог хянан үзэхдээ маш хатуу чанга дүрэм журмыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, эрх зүйн орчин нь мөрдөн тагнах эрх мэдлийг урвуулах ашиглагдахын эсрэг хангалттай хамгаалалтыг бий болгосон гэдгийг шүүхээс баталгаажуулахыг хичээсэн.
 - *Жишээ нь: Францын Круслиний гэх хэрэг* (1990 он). Европын шүүх мөрдөн тагнах ажиллагааны хор хөнөөлтэй мөн чанартай болохыг тогтоож, түүнд “ялангуяа ашиглаж буй технологийн боломж нь үргэлж илүү төвөгтэй болж байлаа ч... чухамдаа нарийвчлан тогтоосон “хуульд л үндэслэх...” ёстой гэж дүгнэсэн. Дээр дурдсанчлан, энэ тохиолдолд утасны яриаг нууцаар чагнах урьдач нөхцөл нь хангалттай тодорхой биш байхад, хувь хүний нууцад хязгаарлалт хийхийг зөвшөөрсөн нь "хууль ёсны байх" шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна гэж Шүүх шийдвэрлэсэн.
 - *Жишээ нь: Нэгдсэн Вант улсын Мэлоуны гэх хэрэг*. Европын шүүхийн шийдвэрийн талаар өмнө нь дээр дурдсан билээ. Шүүхээс "хуульд заасны дагуу" байх гэсэн стандарт хэм хэмжээнд үндэслэн энэ асуудлыг шийдвэрлэсэн нь харьцангуй ховор тохиолддог жишээний нэг юм.

- Энэ асуудлыг тус гарын авлагын онлайн орчин дахь хувь хүний нууц ба мөрдөн тандалт хэсэг /дөрөвдүгээр бүлэгт/-т илүү дэлгэрэнгүй авч үзэх болно.

2. Зөрчилдөөн: Олон нийтийн эрх ашгийн шалгуур үзүүлэлт

- Цахим орчинд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хувь хүний нууц хоёрын хоорондох санаа зовниулсан асуудлууд нь ярвигтай, олон төрөлтэй байдаг. Энд хувь хүний нууцыг юу бүрдүүлж буйгаас жинхэнэ асуудлын ач холбогдол нь илэрнэ. Дээр дурдсанчлан, үндэсний болон олон улсын шүүхийн аль аль нь хувь хүний нууцын талаар тодорхой тодорхойлолт өгөхөөс татгалзсан байна. Харин АНУ-ын шүүхээс субъектив (хувь хүний нууцын бодит хүлээлт), объектив (хувь хүний нууцын байж болохуйц хүлээлтийг) элементүүдийн аль алиныг хамруулахыг илүүтэй санал болгох хандлага бий.

Хэлэлцүүлэг: Энэ үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй зөрчилдөөнт байдал үүсэх үед хувийн нууцын халдашгүй байдлын үзэл баримтлалын хамрах хүрээ нь чухал ач холбогдолтой болдог. Жишээ нь, батлан хамгаалахын сайд нь ресторанд хувиараа оройн зоогонд орсон үед түүний хувийн нууцыг хүндэтгэн үзэх үндэслэлтэй юу, гэхдээ гадаадын зэвсгийн наймаачинтай хамт байсан бол яах вэ? Хэрвээ Ерөнхий сайд нь хэн нэг алдартай одын хуримын ёслолд уригдсан бол яах вэ?

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хувь хүний нууцын хооронд зөрчилдөөн үүсэхэд хэрхэх талаар олон улсын хуулиар маш тодорхой заасан. Үүнд зааснаар уг асуудлыг бүхэлд нь нийтийн ашиг сонирол, эсвэл зарим ижил төрлийн шалгуураар хянан, аль ашиг сонирхол илүү давамгайлж байгааг шийдвэрлэх ёстой. Энэ нь, тухайлбал, Германы Вон Ханноверийн гэх (2004 он, 2012 он) хоёр хэргийг Европын хүний эрхийн шүүхийн өмнө маш тодорхой тогтоогдсон юм.
- Хувь хүний нууц, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө хоёрын хооронд олон нийтийн ашиг сонирхлыг тэнцвэржүүлэхэд хоёр үндсэн нөхцөл байдал хамааралтай байдаг.
 - Нэгдүгээрт, хэдийгээр хувийн шинж чанартай байлаа ч уг мэдээлэл нь хэвлэл мэдээлэл олж авахад хүртээмжтэй үед асуудал гарч ирдэг. Гэхдээ энэ материалыг цаашид түгээх нь үндэсний хууль тогтоомжоор хувь хүний амьдрал (эсвэл зарим нь буруу зүйлтэй холбоотой)-ын талаар үндэслэлгүй хэвлэн нийтлэх ажиллагаа гэж тооцогддог. Ийм тохиолдолд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн элементийн хувьд ч байна уу, эсвэл хувь хүний нууцтай холбоотой дүрэм журмын хэсгийн хувьд ч байна уу, нийтийн эрх ашгийг хамгаалах нь зайлшгүй чухал юм.

- Хоёрдугаарт, мэдээлэл авах эрхэд хувийн нууцын үл хамаарлын зарчмыг хэрэглэгдэх үед олон нийтийн эрх ашгийг харгалзан үзэх нь зүйтэй.
- *Жишээ нь:* Олон улсын тусгай элч нарын 2004 оны Хамтарсан тунхаглалд зааснаар:

Үл хамаарлын нарийн, нягт нямбай тохируулсан тогтолцоотой үед л олон нийтийн болон хувь хүний нууцыг хамааруулан хувийн ашиг сонирхолыг үл тоон мэдээлэл олж авах эрх нь хамгаалагдах боломжтой юм. Хамгаалагдсан ашиг сонирхолд бодитоор хор уршиг учруулах эрсдэлтэй бөгөөд тэрхүү хор уршиг нь мэдээлэл олж авах эрхтэй байх олон нийтийн ашиг сонирголоос давамгайлсан тохиолдолд л зөвхөн үл хамаарал үйлчлэх ёстой.

- *Жишээ нь:* Мөн үүнтэй адил, Европын зөвлөлийн Сайд нарын зөвлөлийн 2002 оны зөвлөмжийн Зарчим IV (2)-т:

Хэрвээ нээлттэй болгох олон нийтийн ашиг сонирхол давамгайлаагүй бол албан ёсны баримт бичигт агуулагдаж байгаа мэдээллийг нээлттэй болгох нь энэ зүйлийн нэг дэх хэсэгт дурдсан ашиг сонирхолд хор хөнөөл учирч болзошгүй, эсвэл учрахаар байвал уг мэдээллийг өгөхөөс татгалзаж болно....

- Хэдийгээр мэдээлэл олж авах эрхийн тухай олон хуульд олон нийтийн ашиг сонирхлыг хувийн нууцыг хамгаалахаас илүүд үзэх үл хамаарлыг баталгаажуулсан байхад, зарим олон хуульд ийм зохицуулалт байхгүй.

Хэлэлцүүлэг: Ер нь олон нийтийн ашиг сонирхол хэрхэн хамгаалагдаж болно гэж та бодож байна вэ? Өмнө дурдсанаар, бид хувийн болон нийтийн ашиг сонирхлын хооронд үүсч болох зөрчилдөөний талаар бага зэрэг ярилцсан. Бид үүнийг хэрхэн шийдвэрлэх вэ?

- Олон улсын шүүхээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн нууцын халдашгүй байдал хоорондын тэнцвэрийг хэрхэн хангах талаарх зарим шалгуур үзүүлэлтийг бий болгоод байгаа юм. Олон улсын шүүхээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжсэн маш хүчтэй төсөөлөл байгаагаас энэхүү шалгуур үзүүлэлтийг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн. Энэ агуулгаараа олон нийтийн ашиг сонирхлын үзэл ойлголт өргөн хүрээтэй тайлбарлагдаж, мөн хэвлэн нийтлэл дэх материалын нийтийн ашиг сонирхол байгаа болохоор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх нь хувийн нууцын ашиг сонирхлоос ерөөсөө илүү давуу гэж үзсэн. Үүний шалтгаан нь маш тодорхой юм: Үзэл бодлын эрх чөлөө, түүнийгээ илэрхийлэх эрх нь ардчиллын үндсэн тулгуур болохын хувьд хувь хүний нууцад хор хохирол учруулж болзошгүй байсан хэдий ч нийгмийн гишүүн бүрийн сайн сайхны төлөө нийтийн ашиг сонирхлын асуудлаарх шийдвэрүүд нь хамгаалагдах ёстой. Өөрөөр хэлбэл, нийгмийн бараг бүхий л мэтгэлцээн ямар нэг байдлаар нэг эсвэл нөгөө хэсгийн хувийн

нууцтай байх ашиг сонирхолтой ямарваа нэг байдлаар холбогдох бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ноцтойгоор хасагдаж хязгаарлагдаж болох юм.

- Вон Ханноверийн хоёр кейс тохиолдолд (доороос харна уу): Европын хүний эрхийн шүүхээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хувь хүний нууцтай байх ашиг сонирхлыг тэнцвэржүүлэн авч үзэх асуудлаар зарим зүйлийг нарийвчлан тодорхойлсон. Эдгээр кейс хэргүүдэд, нийтлэлд олон нийтийн ашиг сонирхол байгаа учраас үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний сонирхол нь ерөөсөө давамгайл байна гэж Европын шүүх үзжээ. Үүнд тулгуурлаад, "олон нийтийн ашиг сонирхлын бүхий л асуудлаарх мэдээлэл, үзэл санааг илэрхийлэхдээ түүний үүрэг, хариуцлагыг нийцүүлэх" нь хэвлэл мэдээллийн үүрэг юм гэсэн хэвшин тогтсон байр суурь байдаг.²³
- Мөн үүнтэй ижил хандлага нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хувийн нууцтай илүү ойр хамааралтай нэр төрийн эсрэг тэнцвэржүүлэн үзэхдээ мөн дагаж мөрдөх нь түгээмэл байдаг. Олон улсын шүүхээс ийм үед нийтийн ашиг сонирхлын асуудалд холбогдох үг хэлэхдээ онцгой эрх хэмжээг зөвшөөрснөөрөө ач холбогдлыг нь дахин улам илүү итгэл найдвартай болгосон. Тиймээс гүтгэлгийн хэргээр эрүүгийн хариуцлагад татсан *Коста Рика улсын Херрера Уллоагийн гэх хэргийг* Хүний эрхийн Америк дундын шүүхээс шийдвэрлэхдээ:

Энэ бий болсон нөхцөл байдлын хувьд, нийтийн албан тушаалтан болон төрийн албатай адилтган үзэх чиг үүргийг хэрэгжүүлж буй бусад хувь этгээдүүдийн талаарх мэдэгдэл тайлан нь үнэхээр ардчилсан тогтолцооны үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаарх өргөн хүрээний яриа хэлэлцүүлгийн эрх чөлөөг олгосон Конвенцийн 13(2) дугаар зүйлд логикоор, зүй ёсоор нийцсэн гэж үзсэн. (2)

- *Жишээ нь:* Энэ санааг дэмжсэн зохицуулалтыг 1998 оны Их Британийн Хүний эрхийн тухай хуулийн 12 (4)-т заасан хэсгээс олж болно:

Хариуцагчийн гомдолд холбогдох материалыг хянан шийдвэрлэж байгаа, эсхүл сэтгүүл зүйн, утга зохиол, уран сайхны материал (эсвэл ийм материалтай холбоотой хийгдсэн) болохыг нь шүүхээс тогтоож байгаа үед үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай Конвенцийн заалтын ач холбогдлыг шүүх тухайлан харгалзсан байх ёстой. Үүнд:

- (a) хэм хэмжээ нь
 - (i) материал байгаа, эсвэл энэ талаар олон нийт мэдэх боломжтой тухай; эсвэл
 - (ii) хэвлэгдэх материал нь олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, эсвэл нийцэхээр бол;
- (b) Хувийн нууцтай холбоотой ямар нэг код байгаа

²³*Von Hannover v. Germany*, 2004 оны 6 сарын 24, Өргөдөл No. 59320/00, пара. 60.

ХБНГУ-ын Вон Ханноверийн хэргүүд

2004 он, 2012 оны Германы Вон Ханноверын хэргийг шийдвэрлэсэн Европын хүний эрхийн шүүхийн хоёр шийдвэрээр хувь хүний нууцын талаар зөвшөөрөгдөхүйц хэм хэмжээг тогтоосон байна. Эхний хэрэг нь Монако улсын Каролайны гүнжийн морь унаж буй, амралтын өдрөөрөө цанаар гулгаж буй, мөн хувийн эдлэн газрынхаа нуурын эрэг дээр бүдэрч унаж байх үеийнх нь фото зургуудтай холбоотой хэрэг юм. Эдгээр зураг Германы нэгэн хувийн сэтгүүлд хэвлэгдсэн бөгөөд эрхээ зөрчигдлөө гэж өргөдөл гаргажээ. Германы шүүхээс дийлэнх зургийг (гүнжийн хувийн нууцад хүлээн зөвшөөрөхүйц газар авсан болон түүний хүүхдүүд оролцсон зураг зэрэг зарим тодорхой зурагнаас бусад) нь хэвлэн нийтэлснийг дэмжин шийдвэрлэжээ.

Хоёр дахь хэргийн хувьд, нөхцөл байдал нэлээд адилханаар шийдвэрлэсэн юм. Монако улсын хаан ширээнд сууж буй Хун тайж Рэйнирийн өвчний асуудалд голчлон чиглэсэн фото зургууд болон түүний гэр бүлийнхэн хунтайжийг өвчтэй үед асран хамгаалж байсан нөхцөлийг харуулсан нь үл хамааралд хамаарна.

Эхний хэргийг Европын шүүхээс шийдвэрлэхдээ:

Энэ хэргийн хувьд, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эсрэг хувийн амьдралын талаарх мэдээллийг хамгаалахдаа тэнцвэрийг хангах ёстой гэж шүүх үзсэн. Фото зургууд, хэвлэлийн нийтлэлээр нийтлэг ашиг сонирхолын төлөө яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулсан болохыг нь шүүхээс ямагт онцлон тэмдэглэдэг²⁴.

Мөн шүүхээс тайлбарлахдаа:

Улс төрчийн хувьд албан ажлын чиг үүргээ хэрэгжүүлж буйтай нь холбоотой ардчилсан нийгэмд яриа хэлэлцүүлэг өрнүүлэхэд чиглэсэн баримт фактыг хэвлэн нийтэлсэн үү, эсвэл, тухайлбал, албан ажлын чиг үүргээ хэрэгжүүлээгүй байхад нь хувь хүний хувийн амьдралынх нь талаар нарийвчилсан мэдээ сурвалжлага хийсэн үү гэдэг хоёрын хооронд үндсэн онцлог ялгааг олж тогтооход шүүхээс анхааран авч үзсэн гэжээ.²⁵

Германы шүүхээс Каролайн гүнж бол орчин үеийн нийгмийн “үлгэр дуурайлал болохуйц” этгээд мөн бөгөөд тэрээр олон нийтийн нүдэнд ил харагдахуйц газар байсан л бол хувийн нууцтай байх ямар ч эрх үүсэхгүй гэж үзжээ. Европын шүүх үүнийг шийдвэрлэхдээ энэ стандарт хэм хэмжээ

²⁴Мөн тэнд., пара. 60.

²⁵Мөн тэнд., пара. 63.

нь албан ажлын чиг үүргээ хэрэгжүүлж байгаа улс төрчдөд тохиромжтой байж болох хэдий ч, энэ хэргийн хувьд хэрэглэх боломжгүй байжээ гэж үзсэн. Шүүхээс өргөдөл гаргагчтай холбогдуулан "хэвлэл мэдээлэл нь гүнжийг албан ажлынхаа ямар нэг чиг үүргийг хэрэгжүүлээгүй байхад, түүнийг хааны гэр бүлийн гишүүн гэдэгт л зөвхөн үндэслэсэн байна" гэж тэмдэглэжээ.²⁶

Хоёр дахь хэргийн хувьд, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон хувийн нууцын хамгаалалтын тэнцвэрийг хангахдаа шүүхээс хэд хэдэн зарчмыг харгалзан үзсэн. Үүнд:

- уг нийтлэлийн олон нийтийн ашиг сонирхлын асуудалд хувь нэмэр оруулж буй хэр хэмжээ (параграф. 109);
- тухайн хүний нэр хүндийн түвшин болон мэдээ сурвалжлагын сэдэв (параграф. 110);
- тухайн хүмүүсийн урд өмнө нь биеэ авч явсан байдал (параграф. 111);
- нийтлэлийн агуулга, хэлбэр, үр дагавар (параграф. 112); болон
- фото зурагнуудыг авсан орчин байдал (параграф. 113).

Ерөнхийд нь авч үзвэл, олон нийтийн ашиг сонирхлын асуудлаарх хэлэлцүүлэгт зарим талаар хувь нэмэр оруулахуйц фото зургууд байсан хэдий ч, эрхийг нь өргөтгөн хүлээн зөвшөөрөх бэлтгэлтэй байх асуудал шүүхэд тулгарсан. Магадгүй Каролайн гүнжийн далайн эрэг дээр бүдэрч унаж байх үеийн фото зургууд нь хамгийн шилдэг жишээ болсон эхний хэргийн хувьд энэхүү хувь нэмэр нь бүрэн хангалтгүй байсан ч, зарим тодорхой дүгнэлтэд хүргэсэн. Хоёр дахь хэргийн хувьд, Монакогийн Вант улсын хааны бүрэн эрхийг хэрэгжүүлж байх үедээ хун тайж III Райнерийг өвчинд нэрвэгдсэн талаарх нийтлэл, мөн энэ өвчний үед түүний гэр бүлийн гишүүдийн биеэ авч яваа байдал" бол олон нийтийн санаа зовоосон асуудлыг тээж байна гэж шүүхээс үзсэн юм.²⁷

Хэлэлцүүлэг: Та олон нийтийн ашиг сонирхлыг үнэлэхэд анхааралдаа авч үзэх ёстой зарим асуудлын тухай боддог уу? Хэрэв Барууны улс орнуудад Монгол шиг орон байсан бол ялгаатай байх байсан гэж бодож байна уу? Үүнтэй холбогдон анхаарвал зохих бусад ямар асуудал байж болох?

- Хувийн нууцыг хамгаалах дүрэм журмын хэрхэн хэрэглэж буй талаар кейс тохиолдлуудаас ижил төсөөтэй асуудлууд гарч ирдэг.

- *Жишээ нь:* Нэгдсэн Вант улсын Мослейн гэх хэрэг. Формула нэг уралдааны захирал Макс Мослэйн "F1 босс

²⁶Мөн тэнд., пара. 72.

²⁷*Von Hannover v. Germany* (No. 2), 2012 оны 2 сарын 7, Өргөдөл Nos. 40660/08 ба 60641/08, пара. 117.

Нацистуудын цэнгээнээс 5 биеэ үнэлэгчтэй наргиж өвчин авчээ” гэсэн гарчигтай бэлгийн ажил хийж байгаа хувийн зургуудыг хэвлэн нийтлэсэн байна. Мослэй Их Британийн шүүхээс заргаа авсан. Учир нь олон нийтийн ашиг сонирхолд хамаарах үйл явдалд Нацист сэдэв биш байсан гэдгээр сонин буруутгагдсан. Тэрээр өмнөх материалын цаашид хэвлэн нийтлэхээс урьдчилан сэргийлэхийн тулд шийдвэрийг татгалзаж байсан; ямар ч тохиолдолд энэ материалын эхний нийтлэлээс гэм хор учирсан гэж зарга мэдүүлсэн. Европын шүүх энэ санааг үгүйсгэсэн. шийтгэх үндсэн зарчим дээр боловсруулах, энэ нь бусад зүйлсээс заасан:

Шүүх нь маргаантай хэдий ч, ардчилсан нийгэм дэх олон нийтийн нийтлэг ашиг сонирхлын яриа хэлэлцүүлэгт хувь нэмэр оруулахуйц баримт фактыг мэдээлж тайлагнасан болон хувь хүний хувийн амьдралын талаар баталгаагүй мэдээлэл хийсэн хоёрын хооронд ялгаа заагийг тогтоохоор мөн л дахин давтан хянан үзсэн. Ардчилалд хэвлэл мэдээллийн өмнө нь гүйцэтгэж байсан онцгой үүрэг роль болоод түүний "олон нийтийн хоточ нохой"-н үүрэг хариуцлага нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний аливаа хязгаарлалтыг нарийвчлан тогтооход авч хэлэлцэхүйц чухал ач холбогдолтой юм. [Лавлагааг устгасан]²⁸

Гэм хорын хохирлыг урьдчилан харахын тулд шүүх дараах зүйлд анхаарвал зохино:

Шүүхээс үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний тухай ноцтой сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэхийн тулд ямар нэгэн "нийтийн ашиг сонирхол" бий болохгүй гэдгийг дараа нь тооцсон байлаа ч, "нийтийн ашиг сонирхол" байгаа гэдгийг хангалттай үндэслэл тогтоож чадахгүй байгаа итгэл үнэмшлийг анхааралтай хэлэлцэн шийдвэрлэдэг.

Үр дүнд нь, хэтэрхий бүрхэг, үр ашиг нь хангалтгүй байж болохуйц шаардлага тавьсан нь бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд маш ярвигтай нөлөөг үзүүлсэн гэж нь тооцсон юм.

Хэлэлцүүлэг: Та энэ кейс тохиолдлын талаар юу гэж бодож байна вэ? Олон нийтэд нээлттэй болсон мэдээллийг Mosley-гийн хувийн нууцтай байх эрх ашгийг нэг удаа хэрхэн сэргээсэн байж болох вэ? Ийм төрлийн асуудлыг шийдвэрлэх өөр бусад арга зам бий юу?

²⁸2011 оны 5 сарын 10, Өргөдөл No. 48009/08, пара. 114.

Ишлэл/ Ном зүй

1. Эндрю Пуддэфэтт, Тоби Мендел, Бен Вагнер, Диксий Хаутин болон Наталья Топпес, ***Интернэт дэх хувь хүний нууц ба Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын судалгаа*** (2012 он, Парис, ЮНЕСКО). Дэлгэрэнгүйг: unesdoc.unesco.org/images/0021/002182/218273e.pdf.
2. Тоби Мендель, ***Олон нийтийн мэдэх эрх ба хөгжин зугаацах эрх чөлөө нь: Хэрэглэгчийн өнцгөөс мэдээллийг нягтлах нь***, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болон Хувийн нууцлалтай байх эрхийн тухай 1999 оны бага хурлын баримт бичиг. Дэлгэрэнгүйг: <https://www.article19.org/data/files/pdfs/publications/freedom-of-information-foi-vs.-privacy.pdf>.
3. Эрик Varendt, ***"Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба Хувийн нууцын халдашгүй байдлыг тэнцвэрүүлэх нь: Страсбургийн шүүх хууль зүйн"*** (2009 он), Хэвлэл мэдээллийн хуулийн сэтгүүл-49

Хувийн нууцтай холбоотой дасгал ажил

Модуль 3: Хувь хүний нууц, Өгөгдөл хамгаалалт ба Мэдээлэлтэй байх эрх

Хэлэлцүүлэг: Хувь хүний нууц болон өгөгдөл хамгаалалт хоёрын ялгаа нь юу вэ? Эсвэл эдгээр нь үнэхээр ижил зүйл юм уу? Хэрэв ялгаатай гэж үзэж байгаа бол үндсэн ялгаа нь юу байх вэ?

1. Өгөгдөл хамгаалалт ба Хувь хүний нууц

- Өгөгдөл хамгаалах үзэл санаа нь хувь хүний нууцыг хамгаалах асуудлаас харьцангуй сүүлд буюу ялангуяа засгийн газраас хувийн мэдээллийг цуглуулах болсон нь тодорхой болсонтой холбоотойгоор түлхүү яригдах болов. Компьютер, түүний дараа интернет гарч ирснээр өгөгдөл хамгаалах үзэл санаа маш хурдтай хөгжиж байна. Өгөгдөл хамгаалах анхны хуулийг 1970 онд Герман улсын Гессе мужид, 1973 онд Швед улс тус тус баталсан байна.
- Өгөгдөл хамгаалах үндсэн үзэл санааны цаана хувь хүний өөрийн мэдээллийг цуглуулах, ашиглах явдлыг хянах эрх байдаг. Энэ нь хувь хүний мэдээллийг маш ихээр цуглуулахаас сэргийлэх хэлбэрээр илэрнэ. Жишээлбэл, зар сурталчилгааны компани зээлийн картын ашиглалтын мэдээллийн санг эзэмшсэнээр хэрэглэгчдийн худалдан авч буй зүйлсэд үндэслэн хувь хүн рүү чиглэсэн зар сурталчилгаа хийнэ.
 - *Жишээ нь:* Нүүр царайг таних програм хангамж одоо маш нарийн болж, нүүр, дүр төрхийн зураг Фэйсбүүк зэрэг газар маш өргөн хүрээнд түгж, цахим зар сурталчилгаанд өргөнөөр ашиглаж, тэдгээр хүмүүсийн хаана явж байгаа байршил, юу худалдаж авч байгаа болон юу сонирхож байгаад чиглэсэн зар сурталчилгаа тэлэх боллоо. Тиймээс компаниуд сайн дураар энэ тохиргоог идэвхжүүлэхгүй байгаа ч технологийн хувьд аль хэдийн хэрэгжиж байна.
- Ихэнх өгөгдөл хамгаалах дэглэм нь хувийн өгөгдөл тухай тодорхойлолтыг өргөжүүлж, тухайн хувь хүнийг тодорхойлох бүх өгөгдөл, мэдээллийг хамруулж байна. Энэ дүрмийг хувь хүний өгөгдөл боловсруулах буюу цуглуулах, хадгалах зэрэг бүх үйлдэлд хэрэглэж байна. Өгөгдөл хянагчид буюу тус дүрмийн хэрэгжилтэд хяналт тавигчдын хувьд өгөгдөл боловсруулах зорилго, утгаас хамааран тухайн этгээд, хуулийн этгээдийг өргөн хүрээнд тодорхойлох болов. Гэвч энэ дүрэм нь автоматаар буюу цахим хэлбэрээр албан бус буюу бодитоос бусад анхдагч системийн өгөгдлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн боловсруулахад хязгаарлагдаж байна.
- Тодорхойлолтын дагуу гар утсан дээр дугаар хадгалж байгаа хувь хүн бол өгөгдлийн хянагч юм. Гэвч, ихэнх өгөгдөл хамгаалах дэглэм бие хүний зүгээс “цэвэр хувийн буюу ахуйн” үйл ажиллагааг боловсруулахад хэрэглэдэггүй.
- Хамгийн чухал асуудал бол хувь хүний нууц ба өгөгдөл хамгаалалтын хоорондын харилцааг тодорхойлох буюу ялгааг гаргаж, өгөгдөл

хамгаалах зарчим нь халдашгүй, хувь хүний нууцтай байх хүний эрхийн хэсэг болохыг танин мэдэх юм.

- Тодруулбал, өгөгдөл хамгаалах нь хувь хүний нууцтай яг адил зүйл биш, ялгаатай бөгөөд хувь хүний нууцын хамгаалалт болон өгөгдөл хамгаалах дүрмийн хооронд ихээхэн ялгаа оршиж байгаа юм. Энэ нь хувь хүний тухай өгөгдлийг төр болон хувийн байгууллагууд системтэйгээр цуглуулахтай холбогдохоор тодорхой асуудал гарч ирдэг. Эндээс өгөгдөл хамгаалалт ба хувь хүний нууцын хоорондын давхцал гардаг бөгөөд олон улсын шүүхээс өгөгдөл хамгаалах дэглэмийн тодорхой элементүүд хувь хүний нууцтай байх эрхийн баталгаа болдог гэж үзсэн.
- Түүнчлэн, өгөгдөл хамгаалах дүрэм нь хувь хүний нууцаас ялгаатай бөгөөд аль аль нь өөрийн хүрээ, нарийвчилсан дүрэмтэй. Өгөгдөл хамгаалалт нь бүхий хувийн өгөгдөлд хэрэглэгддэг бол хувь хүний нууц нь зөвхөн тодорхой хүрээний хувь хүний нууцлах шаардлагатай мэдээлэлд хэрэглэгдэнэ. Мөн өгөгдөл хамгаалах дүрэм нь зөвхөн автоматаар боловсруулдаг өгөгдлийн хүрээнд хэрэглэгдэх хязгаарлагдмал хэм хэмжээ бол, хувь хүний нууц нь аливаа төрлийн бүхий л мэдээлэлд хэрэглэгдэнэ. Тухайлбал, хоёр хүн хамт ресторанд оройн хоол идэж буй үйл баримтад хувь хүний нууц яригдана.
- Энэ нь өөрөө асуудал биш. Гэвч, маш олон өгөгдөл хамгаалах дүрэм нь нийтийн нийтлэг ашиг сонирхолд хувь хүний нууцтай байх эрхийн талаарх хууль зүйн тайлбар шиг хүлээн зөвшөөрөгддөггүй. Өгөгдөл хамгаалах асуудлаарх Европын холбооны 95/46 тоот Удирдамжийн хувьд, өгөгдөл боловсруулах, түүнийг шилжүүлэхийг зөвшөөрснөөрөө нийтийн ашиг сонирхлыг үл хэрэгссэн юм шиг боловч олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн хэрэг биш.²⁹ Зарим дэглэмийн хувьд, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэх шаардлагатай холбоотойгоор улс орнууд сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа, урлаг, боловсрол олгох зорилгоор өгөгдөл хамгаалах нийтлэг дүрмийг уян хатан хэрэглэхийг зөвшөөрдөг.
- Практикт, энэ нь мэдээлэлтэй байх эрхийг хэрэгжүүлэхэд хамгийн их асуудалтай байдаг (дараах хэсгийг харна уу).

Хэлэлцүүлэг: Энэ зүгээс нь хараад, хувь хүний нууц болон өгөгдөл хамгаалахын аль нь илүү чухал юм гэж та бодож байна вэ? Та хувь хүний нууцын дүрэм журмаас гадна өгөгдөл хамгаалах дүрэм журам зайлшгүй байх шаардлагатай гэж бодож байна уу? Ямар төрлийн болзол нөхцөлийг өгөгдөл цуглуулах, боловсруулахад тавих ёстой вэ?

2. Өгөгдөл хамгаалах стандартууд

- Өгөгдөл хамгаалах зарчим нь хүний хувийн нууцтай байх эрхтэй уялдаатай тул түүнийг олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр дэмждэг. Гэхдээ энэ нь бусад өгөгдөл хамгаалах зарчимтай адил тодорхой биш

²⁹ Европын парламент ба хувийн өгөгдөл боловсруулах, эдгээр өгөгдлийг чөлөөтэй шилжүүлэх талаарх хувь хүний хамгаалах Хороо, 1995 оны 10 сарын 24, OJ L 281, р. 31, Зүйл 7(е), 8(4) ба 26(1)(d).

бөгөөд өгөгдөл хамгаалалтыг өөрийг нь хамгаалах тодорхой тогтолцоо бий.

- Европын Хүний эрхийн шүүхийн хувьд Европын хүний эрхийн конвенцийн 8 дугаар зүйлийн дагуу өгөгдөл хамгаалах нийтлэг эрхийг зөвшөөрч байсангүй. Гэвч, сүүлийн үеийн хэргүүдтэй холбоотойгоор өгөгдөл хамгаалахтай холбоотой олон төрлийн нийтлэг эрхийн үзэл санааг хүлээн зөвшөөрөх болов.
- Нэгдүгээрт, Шүүхийн олон шийдвэрт хувийн мэдээллийг цуглуулах нь хувийн амьдралд сөргөөр нөлөөлж болзошгүй тул өгөгдөл хамгаалах нь чухал болохыг тэмдэглэсэн. Тухайлбал, Англи улсын Муррау-гийн гэх хэрэгт тухайн этгээдийг баривчлах үед гэрэл зураг зэрэг хувийн мэдээллийг цуглуулахыг засгийн газрын зүгээс хориглоогүй бөгөөд үүнийг Шүүхээс зөвшөөрсөн. Энэ нь хувийн амьдралд нөлөөлж буй хэрэг боловч тухайн тохиолдолд дээрх эрхийг хязгаарласан байна.³⁰
- *Швед улсын Лийндерийн* гэх хэрэгт хувийн амьдралтай холбоотой мэдээллийг хадгалах, задруулах асуудлыг хамтад нь авч үзсэн.³¹ Энэ хэрэгт мэдээлэл цуглуулахад шаардлагатай процедурын баталгааг Шүүхээс нарийвчлан хэлэлцэж, ардчилсан нийгэмд нууцлах шаардлагыг тэмдэглэсэн. Шүүхээс мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлыг хамгаалах шаардлагатай холбоотой болохыг зөвшөөрсөн. Гэвч, Шүүхээс тэрхүү мэдээлэл цуглуулах үйл ажиллагаа нь “мэдээллийг урвуулан ашиглахын эсрэг зохистой, үр нөлөөтэй баталгаа” шаардлагатай болохыг тэмдэглэсэн байна.³² Ингэхдээ зөвхөн гэмт хэрэг хянан шийдвэрлэх болон иргэний харьяалал олгох эсэхийг шийдвэрлэх зорилгод мэдээллийг хувь хүний хяналтаас хэтрүүлэн ашиглах нь мэдээллийг хамгийн багаар ашиглах тухай заалт бүхий холбогдох хуульд нийцэхийг тэмдэглэсэн байна. Мөн шүүхээс тус системд хяналт тавих тоглогчид нь парламентын гишүүдээс гадна Хууль зүйн канцлер, Омбудсмен болон Парламентын хууль зүйн байнгын хороо болохыг онцгойлон нэрлэжээ.
- Хоёрдугаарт, нийтийн байгууллагууд хувь хүний нууцад халтайгаар хувийн мэдээллийг түгээхтэй холбоотой асуудлыг хянан шийдвэрлэсэн. Финлянд улсын Z. гэх хэрэгт гол асуудал нь ХДХВ-ийн халдвартай байж болзошгүй талаарх үйл баримт бүхий өргөдөл гаргагчийн тодорхой мэдээллийг шүүн таслах үйл ажиллагаанд задлахтай холбоотой байсан. Үүнийг шүүхээс өргөдөл гаргагчийн хувийн амьдралтай байх эрхэд сөргөөр нөлөөлнө гэж шийдвэрлэсэн. Мөн шүүхээс хувийн өгөгдөл, ялангуяа эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах нь “хувийн болон гэр бүлийн амьдралыг хүндэтгэх эрхийг бодитоор хэрэгжүүлэх үндсэн нөхцөл” гэж үзсэн.³³ Тодруулбал, эрүүл мэндийн мэдээллийн мөн чанартай холбоотойгоор “аливаа улс тухайн мэдээллийг өвчтөний зөвшөөрөлгүйгээр, шүүхийн хяналтгүйгээр задруулахгүй байх арга хэмжээ авах, тэрхүү мэдээллийг найдвартай хамгаалах үр дүнтэй

³⁰ 1994 оны 10 сарын 28, Өргөдөл No. 14310/88, пара. 86.

³¹ 1987 оны 3 сарын 26, Өргөдөл No. 9248/81. Мөн *Rotaru v. Romania*, тэмдэглэл 10.

³² *Мөн тэнд.*, пара. 60.

³³ 1997 оны 2 сарын 25, Өргөдөл No. 22009/93, пара. 94.

баталгаа бүрдүүлэх” шаардлагатай гэжээ.³⁴ Мөн хязгаарлагдмал хүрээнд тодорхой нотлох баримтыг задруулахтай холбоотойгоор шүүхээс эрүүгийн ноцтой хэрэгт өргөдөл гаргагч нь нотлох баримтын ач холбогдол бүхий мэдээллийг задлахаас татгалзах зохих бололцоотой байх нь зүйтэй гэдэгт анхаарал хандуулсан байна.³⁵ Гэхдээ зохих нөхцөл, боломж бүрдсэн үед тухайн мэдээллийг арван жилийн дараа олон нийтэд задруулах, түүнчлэн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг задруулах (тухайн этгээдийн нэрийг зарлах зэрэг) боломжтой гэж шүүхээс үзсэн байна.³⁶

- Гуравдугаарт, зарим хэрэгт, ялангуяа Румын улсын *Rotaru* хэрэгт илэрхий худал байсан мэдээллийг няцаах эрхийг заасан.³⁷ Энэ хэрэг нь аюулгүй байдлын албаны авсан илэрхий худал мэдээллийг өргөдөл гаргагч няцаах буюу залруулах бололцоотой байхтай холбоотой байсан.
- Энэ шийдвэрээс хувийн мэдээллийг нийтийн салбарт цуглуулах, түгээх нь үргэлж хувийн амьдралтай холбоотой асуудал үүсгэдэг болох нь тодорхой байна. Түүнчлэн, ардчилсан нийгэмд тухайн цуглуулсан, түгээсэн мэдээллийг үнэлэх эсэхтэй холбоотойгоор Шүүхээс мэдээллийг хэрхэн ашигласныг үнэлнэ. Мөн шүүхээс агуулгын хувьд алдаатай гэж үзсэн мэдээллийг няцаах буюу залруулах эрхийг баталгаажуулсан. Шүүхээс бие даасан хяналтын байгууллага чухал болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд тэдгээр байгууллагын хувьд өгөгдөл хамгаалахтай холбоотой асуудлыг шийдвэрлэх боломжтой байх шаардлагатай.
- Практикт, өгөгдөл хамгаалах дэглэм дэлхийн олон бүс нутаг, үндэсний түвшинд байдаг. Тухайлбал, Ази-Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АРЕС)-ын хувьд өгөгдөл хамгаалахтай холбоотой дүрмийг Нууцлалын хүрээнд баталсан.³⁸
- Дэлхийн түвшинд, НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 45/95 тоот тогтоолоор компьютерт хадгалагдаж буй хувийн өгөгдлийг зохицуулах удирдамжийг баталж, түүнд үндэсний хууль тогтоомжоор өгөгдөл хамгаалахтай холбоотой үндсэн арван зарчмыг дараах байдлаар нэгтгэн тогтоосон:
 - *Хууль ёсны болон шударга байдал*: өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа нь шударга бөгөөд хууль ёсны байх ёстой бөгөөд НҮБ-ын Дүрмийн зорилго, зарчимд харшлах ёсгүй.
 - *Үнэн зөв байдал*: өгөгдөл хянагчид өгөгдлийг үнэн зөв, хамааралтай байгаа эсэхийг шалгаж, хянах үүрэгтэй бөгөөд алдаа гаргахаас зайлсхийх ёстой.
 - *Зорилго-Үзүүлэлт*: өгөгдөл цуглуулах үйл ажиллагаа нь хууль ёсны бөгөөд өгөгдлийн эзний анхаарлыг татсан байх, өгөгдлийг бусад этгээдэд ашиглагдаагүй, зорилготой, өгөгдөл нь зөвхөн тухайн зорилгод шаардлагатай хугацаагаар хадгалагдах ёстой.
 - *Сонирхогч этгээд нэвтрэх боломжтой байх*: өгөгдлийн эзэн

³⁴ Мөн тэнд., пара. 96.

³⁵ Мөн тэнд., пара. 101-109.

³⁶ Мөн тэнд., пара. 111-113.

³⁷ Тэмдэглэл 10, пара. 46.

³⁸ Энд үз: http://publications.apec.org/publication-detail.php?pub_id=390.

тухайн өгөгдлийг хэрхэн ойлгомжтой хэлбэрээр цуглуулах, боловсруулах, нэвтрэхийг мэдэх эрхтэй байх бөгөөд тухайн өгөгдлийн хөдөлгөөнийг саатуулахгүй, арилгахгүй буюу устгахгүй.

- *Ялгаварлан гадуурхахгүй байх*: эдгээр зарчмыг бодитоор хэрэгжүүлэхийг ялгаварлан гадуурхах аливаа онцгой тохиолдол гэж байх ёсгүй.
- *Аюулгүй байдал*: зөвшөөрөгдөөгүй этгээд хандах, урвуулан ашиглах, бохирдуулах зэрэг байгалийн болон хүний эрсдэлээс өгөгдөл хамгаалах зохистой арга хэмжээ авах ёстой.

Хэлэлцүүлэг: Эдгээр стандарт хэм хэмжээг та юу гэж бодож байна вэ? Тэдгээр нь утга ач холбогдолтой юм шиг санагддаг уу эсвэл ойлгомжгүй байна уу? Тэдэнд ямар нэгэн тулгарч болзошгүй асуудлуудын талаар юу гэж бодож байна?

- Энэ удирдамжаар зөвхөн үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эрүүл мэнд, ёс суртахуун, мэдээллийн болон бусад эрхийг хамгаалах шаардлагаар эхний таван зарчмын хувьд хязгаарлалт тогтоож болохыг зөвшөөрсөн. Мөн хараат бус хяналтын эрх бүхий байгууллага эдгээр зарчмыг мөрдүүлж, хариуцлага хүлээлгэх тогтолцооны дагуу дүрэм зөрчсөн бол хариуцлага хүлээлгэх хэрэгтэй болохыг уриалсан. Түүнчлэн, хамгаалалтын арга хэмжээ санал болгоогүй улс орнуудын мэдээллийн эргэлтэд хязгаарлалт тавихыг уриалсан.
- Европын холбооны хувьд өгөгдөл хамгаалах хамгаалалтын хүчирхэг, дэвшилтэт тогтолцоог бүрдүүлж, энэ салбарт манлайлагчийн үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд бусад улс орны өгөгдөл хамгаалах хуулиудад нөлөөлж байна. Европын холбооны өгөгдөл хамгаалахтай холбоотой дүрэм нь түүний 28 гишүүн улсад хүчин төгөлдөр хэдий ч бусад улс оронд түүнийг жишиг болгон батлах болжээ.
- Үүний нэг шалтгаан нь Европын холбоо нь худалдааны харилцаатай ч өгөгдөл хамгаалах зохих дүрэмгүй улс оронд өгөгдөл, мэдээлэл хуваалцах, түгээхийг энэ дүрмээр хориглож байгаатай холбоотой юм.
 - *Жишээ нь*: Европын холбоо нь өгөгдөл хамгаалах зохих стандарттай улсуудыг батламжлах тогтолцоотой бөгөөд Швейцар, Канад, Аргентин зэрэг улсууд энэ хөтөлбөрийг баталсан. Гэвч, АНУ-ын хувьд хувийн хэвшлийн оролцогчдын өгөгдөл хамгаалах асуудлыг нэгдсэн хуулиар зохицуулах боломж багатай тул түүний дүрэм нь “зохих” хэмжээний чанаргүй. Үүнтэй холбоотойгоор, Худалдааны яамнаас Олон улсын аюулгүй нууцлалын зарчмын гэрчилгээжүүлэх хөтөлбөрийг боловсруулсан. Энэ нь сайн дурын шинжтэй хөтөлбөр бөгөөд Европын өгөгдөл хамгаалах дүрэмд нийцсэн тус хөтөлбөрийн долоон зарчмыг хэрэгжүүлэх сонирхол, эрмэлзэлтэй компаниуд гэрчилгээ авахаар өргөдөл гаргаж болох бөгөөд түүндээ өгөгдөл цуглуулах зорилго, олж авсан өгөгдлөө гуравдагч этгээдэд дамжуулах байдлаар хувь хүний эрхийг хөндөхгүй байх, өгөгдөлтэй холбоотой аюулгүй

байдлын шаардлагыг хангасан болохоо мэдэгдэнэ. Тийнхүү гэрчилгээ авсан бол компаниуд Европын холбооны дүрмийн зорилгын дагуу хувь хүний өгөгдлийг зохих ёсоор хамгаалах үүрэгтэй болно. Гэвч, дээрх аюулгүй нууцлалын дүрмийг 2015 оны 10 дугаар сард Европын шүүхээс хэрэгсэхгүй болгосон бөгөөд түүнийг 2016 оны 6 дугаар сард Европын холбоо-АНУ-ын Нууцлалын хамгаалалтаар сольсон. Энэ нь цаашид хэрхэн үйлчлэх талаар шүүмжлэл өрнөсөөр байна.

Хэлэлцүүлэг: Ийм аргаар өөрийн нөлөөг үзүүлэх нь Европын Холбооны хувьд зохистой юм шиг санагдаж байна уу? Энэ нь өөрийн хувийн мэдээллээ өөрийн дүрмийн дагуу авч хэлэлцэнэ гэж баталгаажуулах нь зөвхөн шударга арга зам юм уу, эсвэл илүү нутаг дэвсгэрийн нөлөөллийн бодит хэлбэр юм уу?

- Европын гол хэм хэмжээ нь Европын холбооны 95/49 тоот өгөгдөл хамгаалах асуудлаарх Удирдамж бөгөөд түүнийг 2018 онд шинэ дэглэмийн дагуу солих юм. 95/46 тоот Удирдамжийн үндсэн арга зам нь бусад өгөгдөл хамгаалах дэглэмтэй уялдаж, өргөн хүрээний хэм хэмжээнд болон хязгаарлалт, онцгой тохиолдолд аль алинд нь хэрэглэгддэг.
- Тус тогтолцоо нь дараах гол элементээс бүрдэнэ. Үүнд:
 - Хувийн өгөгдөл болон өгөгдөл боловсруулах гэх ойлголтын өргөн тодорхойлолт
 - Хувийн өгөгдлийг удирдах зарчмууд: шударгаар боловсруулах, тухайлсан тодорхой зорилготой байх, тэрхүү зорилго нь зохих ёсны, хамаарал бүхий бөгөөд тохиромжтой байх, үнэн зөв, шинэчлэгдэж байх төдийгүй шаардлагатай хэмжээнд хадгалах.
 - Өгөгдөл эзэмшигчийн эрхүүд: хянагчийн тухай мэдээлэлтэй байх, ойлгомжтой хэлбэрээр өгөгдөл олж авах, өгөгдлийг арилгах буюу устгахыг шаардах.
 - Хянагчийн зүгээс хяналтын байгууллагад мэдэгдэх, улсын бүртгэлд хадгалах үүрэг
 - Оролцогч этгээдүүдэд хүртээмжтэй арга хэмжээ
 - Зөвхөн зохих хамгаалалтын арга хэмжээ авсны үндсэн дээр өгөгдлийг шилжүүлэх
 - Бие даасан байгууллага хяналт тавих
- Тус дүрмийн хувийн өгөгдлийг боловсруулахад хяналт тавихтай холбоотой нөхцөл нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 45/95 тоот тогтоолд жагсаасан эхний гурван зарчимтай адил агуулгатай.
- Дээрх дүрмийн дагуу “ашиглах болон ил тод байх ёстой мэдээллийг” өөр хэлбэрээр боловсруулсан нь мэдээлэл ашиглахтай холбоотой хэм хэмжээг зөрчсөнд тооцогдохгүй.³⁹

³⁹ Ирландын өгөгдөл хамгаалалх комисс, Өгөгдөл хамгаалах журам 3: хувь хүний мэдээллийг ашиглах, цаашид боловсруулах нь.
<http://dataprotection.ie/viewdoc.asp?DocID=25>.

- Хувийн өгөгдлийг боловсруулахад дараах үндсэн дүрмийг баримтална. Үүнд:
 - шударга, хуулийн дагуу боловсруулсан;
 - тусгайлан, тодорхой, хууль ёсны зорилгоор боловсруулсан бөгөөд эдгээр зорилгод нийцэхгүй арга хэлбэрээр боловсруулаагүй байх. Өгөгдлийг түүх, статистик болон шинжлэх ухааны зорилгоор боловсруулахыг Гишүүн улсын зохих хамгаалалтын арга хэмжээнд нийцээгүй гэж үзэхгүй;
 - өгөгдлийг цуглуулах, боловсруулах зорилго нь зохих ёсны, хамаарал бүхий болон зохих хэмжээтэй байхад чиглэнэ;
 - үнэн зөв, шаардлагатай хэлбэрээр шинэчилж байх; өгөгдлийг худал, бүрэн бус байхаас сэргийлэх буюу тийм өгөгдлийг цуглуулах, цаашид боловсруулахгүй байх, устгах, засах арга хэмжээг байнга авч байх;
 - Өгөгдлийн эзэмшигчийг тодорхойлохыг зөвшөөрдөг хэлбэрээр өгөгдлийг цуглуулах, боловсруулах. Гишүүн улсууд хувийн өгөгдлийг түүх, статистик, шинжлэх ухааны хэрэгцээнд урт хугацаагаар хадгалахуйц зохих хамгаалалтын арга хэмжээ авна.

Хэлэлцүүлэг: Та хэрэгцээ шаардлагатай байж болох бусад дүрмийн талаар юу гэж бодож байна вэ? Эдгээр дүрмүүд нь цаашид хэрэгтэй юм шиг санагдаж байна уу? Ямар нэгэн зүйл болбол та юуг устгах вэ?

- Өгөгдөл эзэмшигчийн зөвшөөрлөөр өгөгдөл боловсруулах үндсэн нөхцөл нь тухайн этгээдтэй гэрээ байгуулах, тэрхүү гэрээнд өгөгдөл хянагчийн хууль зүйн үүрэг, өгөгдөл эзэмшигчийн “амин чухал ашиг сонирхол”-ыг хамгаалах шаардлага, нийтийн ашиг сонирхол, албан ёсны эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа, өгөгдөл хянагч болон гуравдагч этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар заавал тусгана. Эндээс харахад дээрх жагсаалт нь эзэмшигчийн эрх өргөн бөгөөд олон янзаар түүнийг тайлбарлаж байна.
- Өгөгдөл эзэмшигчийн зөвшөөрөл бол энэ тогтолцооны гол хэсэг бөгөөд хоёрдмол утгагүй байх ёстой. Гэвч, ихэвчлэн интернетэд суурилсан үйлчилгээ, түүний стандартад дээрх гэрээний нөхцөл хэрэгждэггүй. Нөгөө талаар ихэнх тохиолдолд өгөгдөл эзэмшигч нь тухайн нөхцөлийг уншдаггүй, магадгүй уншсан ч ойлгоход хүндрэлтэй байдаг. Үүнийг өгөгдөл эзэмшигч зүй бус дарамтад байгаатай адилтган үзэж шүүмжилдэг бөгөөд энэ үед хэн нэгний өгөгдөлд бүхэлд нь хяналт тавих санаа ихэвчлэн давамгайл байдаг.
- Удирдамжид нэгэн адил өгөгдөл эзэмшигчийн тодорхой эрхүүдийг тодорхойлдог. Тухайн этгээд хянагчийг таних мэдээлэлтэй байх, өгөгдөл боловсруулах зорилгыг мэдэх, шударгаар боловсруулах нөхцөлийг хангах, өгөгдөл хүлээн авагч болон өгөгдөлд хандах буюу арилгах эрх зэрэг олон төрлийн мэдээллийг авах ёстой.
- 12 дугаар зүйлийн дагуу өгөгдөл эзэмшигч нь хянагчаас боломжит хугацаанд, хэт их саатал, зардалгүйгээр дараах мэдээллийг авах эрхтэй. Үүнд:

- тухайн өгөгдлийг боловсруулсан эсэх тухай баталгаажуулалт, түүний зорилго, өгөгдлийн ангилал болон хүлээн авагч;
 - өгөгдлийг ойлгомжтой хэлбэрээр түүний эх үүсвэрийн хамт;
 - түүнд шийдвэр гаргахад нөлөөлөхүйц аливаа автомат боловсруулалттай холбоотой логик.
- Хянагчийн зүгээс Удирдамжийг биелүүлээгүй буюу бүрэн бус, буруу өгөгдлийг устгах, хаах шаардлагатай бөгөөд энэ тухай холбогдох гуравдагч этгээдэд мэдэгдэнэ. Өгөгдлийг хадгалж, аюулгүй аргаар боловсруулсан байх ёстой.
 - Улс орнуудын хувьд эдийн засгийн чухал шалтгаанаар, мэдээллийн болон бусад эрхийг хамгаалах зорилгоор үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүргийг хязгаарлаж болох юм.
 - Өөр нэг илэрхий алдагдалтай дүрэм бол хянагч нь хяналтын байгууллагад гуравдагч улсад шилжүүлэхээр санал болгох аливаа өгөгдлийн зорилго, эзэмшигчийн ангилал, хүлээн авагчийн тухай мэдэгдэх үүрэг юм. Ингэж хяналтын байгууллагад мэдэгдэж, хадгалагдсан мэдээллийн бүх боловсруулалтад бүртгэл үйлдэгдсэн байх ёстой бөгөөд олон нийтэд нээлтэй байна. Улсууд энэ бүртгэлийг өргөн хүрээнд олон нийтийн байгууллага, тодорхой нөхцөлтэй этгээдэд өргөн хуваарилж болно.
 - Өгөгдөл эзэмшигчийн эрхийг хамгаалах олон янзын арга хэмжээ байх бөгөөд үүнд өгөгдлийг хууль бусаар буюу хохирол учруулан боловсруулсан хянагчаас нөхөн төлбөр гаргуулах, өгөгдөл гаргагчийн эрхийг зөрчсөн этгээдэд шүүхээс зохих хариуцлага хүлээлгэх зэргийг нэрлэж болно. Хариуцлагыг тухайн дүрмийг зөрчсөн этгээд ногдуулахаар тодорхойлсон байх ёстой.
 - Удирдамж нь хоёр төрлийн байгууллагын бүтцийг дэвшүүлсэн. Нэгдүгээрт, оролцогч улс бүр хянан шалгах, өгөгдөл боловсруулахыг хязгаарлах, хууль зүйн арга хэмжээ авах, гомдол хүлээн авах зэрэг олон төрлийн эрх мэдэлтэй бие даасан хяналтын байгууллага байгуулах ёстой. Хоёрдугаарт, 29 дүгээр зүйлд ажлын хэсэг гэж нэрлэсэн хяналтын байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн зөвлөх чиг үүрэг бүхий баг байгуулах юм.

3. Хувь хүний нууц, Өгөгдөл хамгаалалт ба Мэдээлэл олж авах эрхийн тухай хууль

- Ихэнх улсад мэдээллийн эрх ба өгөгдөл хамгаалах дүрмийг хувь хүний нууцтай холбон төөрөгддөг. Энд дурдсанчлан, өгөгдөл хамгаалах дэглэм нь хувь хүний нууцын болон хувийн материалын хүрээнээс гадна байдаг. Бүх зүйл хувийн амьдралд хамааралгүй тул мэдээллийн эрхийн хүрээнээс бүх мэдээллийг гаргах нь зохисгүй гэдэг нь тодорхой юм. Мэдээлэл олж авах эрхийн тухай хуулиудын сайн туршлага нь бүх мэдээллийг хамруулан тодорхойлохгүйгээр хувь хүний нууцыг хамгаалахдаа тогтоох хязгаарлалтыг тодорхой болгосон.
 - *Жишээ нь:* Өмнөд Африкийн Мэдээлэл олж авахад дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 34 дүгээр хэсэгт “гуравдагч этгээдийн

тухай хувийн мэдээллийг үндэслэлгүйгээр задруулах” нь хувийн нууцын үл хамаарлыг хязгаарлаж буй зохицуулалт болно.

- Асуудлын гол нь хувь хүний нууц ба мэдээлэлтэй байх эрхийн хоорондын тэнцвэрийг хэрхэн зохистой байлгах тухай юм. Мэдээлэлтэй байх эрхийн сайн хуулиудын хувьд хувь хүний нууц хэрэглэхгүй байх тохиолдлуудыг тодорхойлсон байдаг. Жишээлбэл, аль хэдийн олон нийтэд хүрсэн буюу тийнхүү хүргэхийг зөвшөөрсөн мэдээллийг түүнтэй албаны чиг үүргийн дагуу танилцсан эрх бүхий албан тушаалтан нууцлах шаардлагагүй байдаг. Тиймээс Өмнөд Африкийн Мэдээлэл олж авахад дэмжлэг үзүүлэх тухай хуулийн 34 дүгээр хэсэгт “гуравдагч этгээдийн тухай хувийн мэдээллийг үндэслэлгүйгээр задруулах”-аас сэргийлэх онцгой тохиолдлыг зохицуулсан.⁴⁰ Ийм хуулиуд нь хувийн нууцын үл хамаарлыг оролцуулан үл хамаарлын зарчмуудыг тогтоодог. Жишээ нь, тухайн мэдээлэл нь аль хэдийн нээлттэй болсон, эсвэл нийтийн албан тушаалтны албан ажлынх нь чиг үүрэгтэй холбоотой мэдээлэл байвал зөвшөөрөгдсөн гэж үзнэ гэх мэт.⁴¹
- Хамгийн чухал зүйл бол нийтийн ашиг сонирхлын үүднээс мэдээллийг нууцлах хүрээг багасгах ба хувь хүний мэдээллийг задруулахад тэнцвэрийг хангах тухай юм. Энэ хандлага нь үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний олон улсын шүүхээс хүний мэдээлэл авах эрхэд суурилан хийсэн тодорхой тайлбартай нийцэж байна.
- Үүний зэрэгцээ, ихэнх улсад нийтийн ашиг сонирхол эсэхээс үл хамааран хувь хүний нууцыг хэт давамгайл байдлаар тогтоох нь асуудал болж байгаа бөгөөд одоогоор үндсэндээ өгөгдөл хамгаалах нь давамгайлж байна. Энэхүү хувь хүний нууцын хүрээг өргөжүүлэх ашиг сонирхол нь маш их асуудалтай болох нь тодорхой харагдаж байна.
 - *Жишээ нь:* Энэтхэгийн хувь хүний нууцын тухай хуулийн төсөлд өгөгдөл хамгаалах нийтлэг тогтолцоог бүрдүүлэхээр тусгасан бөгөөд энэхүү шинэ хууль нь 2005 оны Мэдээлэл олж авах эрхийн тухай хуулиар тогтоосон дэглэмд нөлөөлөх асуудлаас зайлсхийсэн байна.

Хэлэлцүүлэг: Өгөгдөл хамгаалалт болон мэдээлэлтэй байх эрхийн алийг нь илүү чухал гэж үзэж байна вэ? Тэдгээрийг тэнцвэржүүлэх дээрх дүрэм журам нь шударга юм шиг санагдаж байна уу? Үүнийг хийх өөр бусад арга зам байна гэж бодож байна уу?

⁴⁰ Act No. 2, 2000. <http://www.gov.za/gazette/acts/2000/a2-00.pdf>.

⁴¹ Өмнөд Африкийн хууль, 34 зүйл үз, мөн тэнд.

Ном зүй

1. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол 45/95, Компьютерт хадгалагдаж буй хувийн өгөгдлийн файлуудын зохицуулах удирдамж, Дэлгэрэнгүйг: <http://www.unhcr.org/refworld/publisher,UNGA,THEMGUIDE,,3ddcafaac,0.html>
2. Европын Парламентын болон Зөвлөлийн 1995 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн хамтарсан удирдамж (95/46/ЕС), Хувийн өгөгдөл мэдээллийг боловсруулахтай холбогдсон хувь хүний хамгаалалт болон ийм өгөгдлийг чөлөөтэй шилжүүлэх удирдамж. Дэлгэрэнгүйг: <http://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=CELEX:31995L0046:en:HTML>
3. Эндрю Пуддэфэтт, Тоби Мендел, Бен Вагнер, Диксий Хаутин болон Наталья Топпес, *Интернэт дэх хувь хүний нууц ба Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний олон улсын судалгаа* (2012 он, Парис, ЮНЕСКО). Дэлгэрэнгүйг: unesdoc.unesco.org/images/0021/002182/218273e.pdf.

Модуль 4: Онлайн хувийн нууц ба мөрдөн тагнах

“Мөрдөн тагнах асуудлыг зөгнөсөн таамгуудыг сөхвөл Жорж Орвэлл өөдрөг үзэлтэн байсан болж таардаг.”

- Микко Хиппонэн, Аюулгүй байдлын судлаач
“How the NSA betrayed the world's trust - time to act”, October 2013

Хэлэлцүүлэг: Энэ асуудал Монголын хувьд үүсч байгаа юу? Хууль ёсны аюулгүй байдлыг хангах хэрэгцээг хувь хүмүүсийн төрийн зүгээс хэт мөрдөн тагнахаас ангид байх эрх хоёрыг хэрхэн тэнцвэржүүлж болох вэ?

1. Ерөнхий зарчмууд

- Хувийн нууц нь онлайн харилцаа холбоондоо сэжиглэхгүй итгэхийг, ингэснээр интернэтийг ашиглан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх илэрхийлийг нөхцөлдүүлэхэд амин чухал. Энэ зарчим нь хувийн хэвшил болох интернэтийн үйлчилгээгээр хангагч компаниуд болон арилжааны вэбсайтууд, мөн засгийн газруудад хамааралтай.
- Хүмүүсийн хувийн харилцаа холбоог хэт мөрдөн тагнах ажиллагааг орчин үеийн технологиуд хэд хэдэн байдлаар хялбарчилсан. Оффлайн харилцаа холбоог мөрдөн тагнах нь өндөр чадал бүхий компьютерээр дамжуулсан цахим харилцаа холбоог цуглуулах, боловсруулах нь хэнд ч ойлгомжтой шалтгаанаар илүү амар. Жишээ нь өнгөрсөнд хүмүүсийн утасны яриаг бичиж авах ч, бас шууд тухайн цагт нь чагнадаг байсан бол одоо яриаг чагнахдаа эрсдэлтэй үг хэрэглэж буй эсэхээр нь хялбархан хайж болдог болсон.
- Мэдээлэл цуглуулах, мэдээлэл хадгалах, мэдээллийг боловсруулах гэсэн гурван үндсэн элементийг шинэ технологиудаар өргөн хэмжээнд хялбар хийж болж байна.
- Мэдээлэл цуглуулах тухайд шинэ технологиуд авт оматаар, байнга бидний тухай илүү их мэдээллийг цуглуулах боломжтой болсон. Эдгээр мэдээллийг бид сайн дураараа өгдөг, тухайлбал Фэйсбүүкийн хуудсаараа үзүүлдэг үйлчилгээнийхээ хүрээнд гар утаснаас ирсэн дуудлагуудыг бичдэг. Эсвэл хувийн хэвшлийнхэн бизнесийнхээ ашиг сонирхолын хүрээнд бидний онлайн худалдан авалтын талаар мэдээллийг цуглуулж байдаг.
- Энэ их мэдээллийн ихэнх нь автоматаар хадгалагддаг ба ямарваа тусгай процедургүй үүнийг хийх боломжтой. Жишээ нь идэвхтэй хэрэглэгчийн ухаалаг утсанд хадгалагддаг өгөгдлүүд тухайн хүний байршил, яриа гэх мэт мэдээллийг цогцод нь харуулдаг. Цаашлаад цахим шуудан гэх мэт харилцаа холбооны олон төрлүүдийг автоматаар хадгалдаг ба доторх мэдээллийг компьютерээр хайх боломжийг олгодгоороо хууль сахиулах зорилгоор нэн тустай байдаг. Видео камераар мөрдөн тагнах нь улам ихэсч буй энэ цагт царай таних чадамжтай технологиуд хөгжсөн нь үүний өөр нэг жишээ билээ.
- Мэдээлэл хадгалах салбарын хөгжил нь адил үсрэнгүй байна. Хамгийн

хямд ухаалаг утас нь Британника нэвтэрхий толийн хэвлэмэл бүх ботиудаас агуулагдахаас илүү мэдээллийг хадгалах багтаамжтай. Харин өндөр чадалтай өгөгдөл хадгалах системүүд агуу их мэдээллийг зөвхөн архивлаад зогсохгүй, мэдээллийг татаж авах боломжийг олгож байна.

- Орчин үеийн компьютерүүдийн өгөгдөл боловсруулах чадал нь хурдацтай ихэссэнээр үржүүлэгчийн үүрэг гүйцэтгэж байна. Өнгөрсөнд утасны яриаг чагнахын тулд тухайн утсанд тусгай төхөөрөмж суурилуулах, эсвэл тусгай төхөөрөмжийг идэвхжүүлэх, цаг тухайд нь яриаг бичих, сонсох тусгай процессыг шаарддаг байсан. Үүнийг одоо эрүүгийн хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийн гар утсан дах хураагдсан мэдээллийг технологийн тусламжтайгаар боловсруулахтай харьцуулаад үзээрэй.
- Цаашлаад хэрэгтэй мэдээллийг олж авах нь интернэтийн нэгдмэл харилцаа холбооны дэд бүтцээс хамааран хамаагүй хялбар болсон. Харилцаа холбооны уламжлалт хэлбэрүүд бие даасан, хараат бус сүлжээгээр дамждаг байсан. Шуудан илгээх нь утсаар ярихаас огт тусдаа дэд бүтцээр дамждаг. Хүний бичмэл харилцаа холбоо, утсыг чагнах нь хоёр өөр ажиллагаа шаарддаг байсан. Харин одоо онлайн харилцаа холбоо болох утасны яриа, цахим шуудан, видео хурал гэх мэт нь нэгдсэн өгөгдлийн урсгалыг үүсгэдгээрээ ялгаатай ба мэдээллийг цуглуулахад ч маш дөхөм болсон.

Хэлэлцүүлэг: Энэ талаар юу бодогдож байна? Энэ аюул уу, эсвэл нейтрал технологийн дэвшил үү?

- Ардчилсан орнуудад ч тод ажиглагдаж буй өөр нэгэн хандлага бол энэхүү мэдээллийг хууль сахиулах зорилгоор ашиглах эрх зүйн зохицуулалтуудыг үүсгэж буй явдал нь нэгэн санууштай хүчин зүйл болоод байгаа. Гэмт хэргийн элементүүд, ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэг, терроризм үйлдэхдээ технологийг амжилттай ашигладгаас үүдэн гэмт хэрэгтэй тэмцэхэд бүх арга хэрэгслийг ашиглах шаардлагаас энэхүү нөхцөл үүдэлтэй. Хэдий тийм ч ийн мөрдөн тагнахдаа хувийн нууцын асуудлыг хангалттай шийддэг эсэх нь илт биш тул ийм зохицуулалттай улсуудыг хувийн нууцын эрхийг дэмжигсдийн зүгээс хатуу шүүмжлэлд өртдөг. Улс орнууд Үндсэн хуулийн цэцүүдээр хэлэлцүүлэн хүний эрхэд халдсан хэмээн тогтоолгосон ба Европын холбооны шударга ёсны шүүхээс хууль бус хэмээн хүчингүй болгосон Европын холбооны Өгөгдөл хадгалах тухай тогтоол нь үүний тод томруун жишээ. Цаашлаад хувийн нууцыг чанд хадгалах зарчмыг хэрэгжүүлдэг системуудыг ч хувийн нууцыг хадгалах тогтолцоо нь сул олон оронд буруугаар ашиглах боломж ихтэй.
- Хувийн компаниуд ч мөн энэ асуудал дээр хууль сахиулах салбартай хамтран ажилладаг. Шилэн кабель болон бусад дэд бүтцээр дамжиж буй хэрэглэгчээс үүдэх мэдээллийг дамжуулах үед нь цуглуулах боломж бүрэн нээлттэй байдаг. АНУ-д хэрэглэгчээс үүдэх мэдээллийг АНУ-д төвтэй харилцаа холбооны компаниудтай хамтарч, интернэтийн цөм араг

яс болох сервер судлууд дээр мэдээллийг базан саатуулах цэгүүд үүсгэх мониторингийн төхөөрөмжүүдээр хийдгийг Снөүдэн тайлбарласан.

- Мөрдөн тагнах өөр нэг арга нь deep packet inspection (DPI) буюу өгөгдлийн багцыг бүрэн шалгах арга. Энэ нь интернэтийн мэдээллийн урсгалыг тодорхой түлхүүр үг, эсвэл компьютерийн эх кодын хэсэг зэрэг тодорхой таних тэмдгүүд байгаа эсэхийг автоматаар шалгах явц юм. Өгөгдлийн багцыг нарийн шалгах аргыг хууль ёсны зорилгоор буюу вирус шүүх, интернэтийн үйлчилгээний халдлагаас хамгаалах ашигладаг ч байнга, бүрэн дүүрэн хэрэглэж буй нь мөрдөн тагнах үйл ажиллагааны цар хүрээ, агуулга хэтэрснийг харуулдаг. Түүгээр үл барам дэвшингүй өгөгдлийн багцыг бүрэн шалгах системүүд ямар нэг улс төрчийн талаар сөрөг зүйл вэбсайт дээр бичигдсэнийг арилгаж, эергээр солих гэх мэтээр хэрэглэгч огт мэдэхгүй байдлаар интернэтийн мэдээллийн урсгалыг хялбархан өөрчилж чаддаг.
- Мэдээлэл цуглуулах эдгээр аргуудыг АНУ-д кодтой хоёр дахь хөтөлбөрөөр хэрэгжүүлдэг. PRISM-р АНУ-ын компаниудын серверүүд дээр байрлах хэрэглэгчдийнх нь талаар хадгалагддаг асар их мэдээллийг цуглуулдаг. Үндэсний аюулгүй байдлын агентлаг нь гол гол онлайн болон харилцаа холбооны компаниудын төв серверүүдэд шууд холбогддог, хүссэн хүмүүсийнхээ талаар мэдээллийг цуглуулдаг болохыг Снөүдэний зарласан зүйлсээс харж болдог.
- Бусад улс оронд иймэрхүү хөтөлбөрүүд хэрхэн ажилладаг тухай бидэнд мэдээлэл байхгүй ч өөр олон улс төстэй хөтөлбөртэй, мөн АНУ-тай хамтарч ажилладаг талаар нотолгоо бий. АНУ, Их Британи, Австрали, Канад, Шинэ Зеландын нэгдсэн хөтөлбөр болох “Таван нүд” үүний жишээ.
- Зарим улс орнууд харилцаа холбооны компаниудыг өгөгдлөө тодорхой хугацаанд хадгалах, тэр үед нь аюулгүй байдлын болон хууль сахиулахынхан мэдээллийг авч болох мэдээлэл хадгалах тогтолцоонуудыг үүсгэсэн.
 - *Жишээ:* Эдгээр системүүдийн хамгийн зартай нь Европын холбооны Өгөгдөл хадгалах тухай 2006/24/ЕС тогтоол байсан ба үүний дагуу ЕХ-ны бүр улс орнууд мэдээллийн урсгал, хэрэглэгчдийн утас, интернэтийн хэрэглээний тухай өгөгдлийг интернэтийн үйлчилгээ үзүүлдэг бүх компаниуд зургаагаас хоёр жил хадгалах ёстой тухай хууль батлахыг үүрэгжүүлсэн. Ирландын Цахим эрх байгууллагаас энэ асуудлаар Европын холбооны шударга ёсны шүүхэд нэхэмжлэл гаргасны дараа 2014 оны 4-р сард энэхүү тогтоолыг Европын холбооны Үндсэн эрхийн тунхагт заасан хувийн нууц, мэдээлэл хадгалах заалтуудыг зөрчсөн хэмээн хүчингүй болгосон.

Хэлэлцүүлэг: Ийм зүйлсийг олж мэдээд гайхширч байна уу? Монголд олон нийтийг хамарсан мөрдөн тагнах ажиллагаа явагддаг гэж бодож байна уу? Санаа зовж байна уу? Хятад Монголыг тагнан мөрддөг тухай санаа зовж байна уу?

2. Олон улсын хэм хэмжээ

- Олон улсын шүүхүүдээс тодорхойлсон анхдагч хатуу хэм хэмжээ нь харилцаа холбоог мөрдөн тагнах хөтөлбөрүүдийн хувийн нууцад халдаж буй үйл ажиллагаа бүрэн “хуулийн дагуу, хуульд нийцсэн” байх. Энэ нь харилцаа холбооны мөрдөн тагнах ажиллагааг зөвшөөрсөн хууль тогтоомж хүртээмжтэй, ил, ямар тохиолдолд энэхүү үйл ажиллагаа явагдах боломжтой талаар нөхцөл байдлыг нарийн тодорхойлсон байна гэсэн үг.

- *Жишээ:* 1984 оны *Малоун Их Британий эсрэг* хэргийн дагуу Европын холбооны Хүний эрхийн шүүхэд гаргасан нэхэмжлэлд:

1-р зүйлд заасан хамгаалагдсан эрхүүдийг төрийн байгууллагуудын зүгээс дур мэдэн хязгаарлахын эсрэг дотоодын хууль тогтоомж, эрх зүйн хамгаалалт байх ёстой. Гүйцэтгэх засаглал эрх мэдлээ ялангуяа нууцаар хэрэгжүүлэхэд дур зоргоор хийгдэх үйлдлүүдийн эрсдэл үүсдэг нь хэнд ч ойлгомжтой. Гиймээс хууль тогтоомж нь ямар нөхцөл байдалд иргэдийн хувийн амьдрал болон харилцаа холбоог мөрдөн тагнах боломжтой тухай, ямар нөхцөл байдалд төрийн байгууллагууд энэхүү хувийн нууцад нь халдах нууц, аюул дагуулах боломж бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэхээс өөр аргагүй болох тухай тодорхой заасан байх ёстой.

- Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний асуудлаарх НҮБ-ын Тусгай илтгэгч 2013 оныхоо тайландаа энэ асуудлаар хууль эрх зүйн тодорхой хүрээ шаардагдаж буй тухай тусгасан байдаг:

Үндэсний хууль эрх зүйн зохицуулалт, орчин хангалтгүй байх нь хувийн нууцтай байх болон хувийн холбоо харилцааныхаа нууцыг хадгалах эрхэд дур зоргоор, хууль бусаар халдах хөрсийг үүсгэж, цаашлаад энэ нь үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг хамгаалсныг устгах аюултай байдаг.

- Энэхүү зарчмыг мөн НҮБ болон Америк тивийн улсуудын нэгдсэн байгууллагын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгчдийн 2013 оны Хамтарсан тунхаглалд багтааж өгсөн байдаг.

Хувь хүмүүсийн ашиг сонирхолд дур зоргоор оролцохоос хамгаалах үүднээс хувийн мэдээллийг тагнан олж авах, цуглуулах болон хэрэглэх, асуудал хамаарах хүний мэдээлэл олж авах эрхийг хязгаарлах бүх хязгаарлалтыг хуульд нийцүүлэхийг улс орнууд хангах ёстой. Эдгээр арга хэмжээний мөн чанар, хүрээ, хугацаа, эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх шалтгаан, мөн арга тушаагч, хэрэгжүүлэгч, мониторинг хийх төрийн байгууллагууд болон эдгээрийн эсрэг гомдол гаргах эрх зүйн механизмыг хуулиар хязгаарлан тогтоох ёстой.

- Мөрдөн тагнах үйл ажиллагааны үндэс болох хууль тогтоомж нь

хуулийн дагуу ямар үйл ажиллагаа багтаж буйг тодорхой тодорхойлох ёстой. Үндэсний аюулгүй байдалд бодитоор хамаарах асуудал дээр л мөрдөн тагнах үйл ажиллагаа явагдахыг хангах нь хууль ёсны зорилгын дагуу хувийн нууц болон үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хязгаарлах олон улсын хэм хэмжээний шалгуурыг хангадаг. Зорилгыг нарийн тодорхойлсноор өндөр эрх мэдэл бүхий агентлаг, хөтөлбөрийн мандатаа өргөн хэрэглэх хандлагыг хязгаарладаг. Мөрдөн тагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг зөвшөөрөх хуульд энэхүү үйл ажиллагааны хүрээг нарийн тодорхойлохоос гадна ийм үйл ажиллагаа явуулах аентлагийн эрх мэдлийн талаар аль болох нарийн тусгах ёстой. Мэдээж мөрдөн тагнах үйл ажиллагааг хүний эрхийг ханган хамгаалах үйл ажиллагааны хүрээнд хийх ёстойг заах нь шилдэг арга болно.

Хэлэлцүүлэг: Ийм хууль тогтмоомжид өөр юу багтвал зохих вэ?

- Хоёр дахь үндсэн зарчим нь ил тод байдалтай холбоотой олон улсын ерөнхий хэм хэмжээнээс ургах ил тод байдлыг хангах зарчим.
- Хууль тогтоомж олон нийтэд нээлттэй байх ёстой гэсэн зарчим дээрх тайлбарууд дээр илэрхий байгаа ч Үндэсний аюулгүй байдал ба мэдээллийн эрх чөлөөний тухай Тшванэ зарчмуудын 10Е-д үндэсний аюулгүй байдлын тухай хэрэгцээг ил тод байдалтай хэрхэн тэнвцэржүүлэх талаар заалтад нарийн заасан. Эдгээр зарчмыг иргэний нийгэм болон эрдэм шинжилгээний шинжээчдийн төрөл бүрийн төлөөлөл бүхий эвсэл боловсруулж, НҮБ, Америк тивийн улсуудын нэгдсэн байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Африкийн хүний болон ард түмнүүдийн эрхийн Комисс гэсэн олон улсын байгууллагуудын дөрвөн Тусгай илтгэгчдээс сайшаагдан батлагдсан.
- Зарчим 10Е. Мөрдөн тагнах үйл ажиллагаа:

(1) Мөрдөн тагнах үйл ажиллагааг зохицуулах хууль эрх зүйн ерөнхий хүрээ болон ийм үйл ажиллагааг тушаах, үйл ажиллагааны объектыг сонгох, мөрдөн тагнах үйл ажиллагаагаар олж авсан мэдээллийг хэрэглэх, хуваалцах, хадгалах болон устгах процедуруудын талаарх мэдээлэл нийтэд нээлттэй байх ёстой.

- *Жишээ:* НҮБ, Америк тивийн улсуудын нэгдсэн байгууллага, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Африкийн хүний болон ард түмнүүдийн эрхийн комиссын Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгчдийн 2015 оны Хамтарсан тунхаглалын 8(с)-р зүйлд ил тод байдал нэн чухал болох тухай цохон тэмдэглэсэн байдаг.

Улс орнууд мөрдөн тагнах үйл ажиллагааны системүүд, эдгээрийг зохицуулах эрх зүйн болон бодлогын хүрээний талаар бүрэн ил тод байдлыг байнга хангах ёстой.

- Мөрдөн тагнах үйл ажиллагааны үйл явцыг хууль ёсны шалтгаанаар нийтэд дэлгэхгүй байх нь мөрдөн тагнах үйл ажиллагааны зарчмуудыг зохицуулах эрх зүйн хүрээг нийтэд ил тод байлгахаас өөр асуудал. Тодорхой эрх зүйн хэм хэмжээ, дүрэмгүйгээр мөрдөн тагнах үйл ажиллагаа явуулдаг төрийн эрх мэдэл бүхий байгууллагууд үйл ажиллагааныхаа хүрээ, эрх мэдлээ хэтрүүлэн хэрэглэхийг оролддог. Олон улсын хэм хэмжээг дагахын тулд мөрдөн тагнах үйл ажиллагааг зохицуулдаг хууль нь ямар нөхцөлд мөрдөн тагнах үйл ажиллагаа эхлэх боломжтой, ямар нөхцөлд тухайн байгууллага мандатынхаа дагуу мөрдөн тагнах үйл ажиллагаа эхлүүлдэг, тухайн үйл ажиллагааг эхлүүлэхийг тушаах нөхцөл, мөн ийм ажиллагааны үеэр юу хийж болох ба болохгүйг тодорхой заах ёстой.
- Ил тод байдлын хэрэгцээ эрх зүйн зохицуулалтаас давдаг ба мөрдөн тагнах ажиллагааг хэрэгжүүлэх үйл ажиллагааны ерөнхий зарчим, нөхцөл байдалд мөн хамааралтай байдаг.
 - *Жишээ:* Үндэсний аюулгүй байдал ба мэдээллийн эрхийн тухай Тшванэ зарчмуудад үндэсний аюулгүй байдал ба ил тод байдлыг хэрхэн тэнцвэржүүлэх ёстой талаар ийн заажээ.

Зарчим 10Е. Мөрдөн тагнах үйл ажиллагаа:

...

- (2) Мөрдөн тагнах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагуудын тухай болон ийм үйл ажиллагаа явуулсан тухай статистик мэдээллийг олон нийт бүрэн хүртэх эрхтэй.
 - (3) Цаашлаад аливаа хууль бус мөрдөн тагнах үйл ажиллагааны талаар олон нийт мэдээлэл бүрэн хүртэх эрхтэй. Мөрдөн тагнах үйл ажиллагааны талаарх мэдээллийг уг үйл ажиллагааны объект болсон хүмүүсийн хувийн нууцад халдахгүйгээр байж болох дээд хэмжээнд олон нийтэд мэдээлбэл зохино.
 - (4) Эдгээр зарчмууд нь мөрдөн тагнах үйл ажиллагаанд өртсөн, эсвэл өртсөн гэж итгэж буй хүмүүсийн материалаг болон процессын эрхэд нэмж үл халдахыг, мөн олон нийтийн мэдэх эрхийг хангахыг чиглэсэн билээ.
 - (5) Энэхүү зарчмын ил тод байдлыг дээдэлсэн агуулга нь гадаадын засгийн газруудын мөрдөн тагнах үйл ажиллагаа, түүгээр олсон мэдээлэлд хамаарахгүй.
- Тодорхой хэргүүд, мөрдөн хянах ажиллагааны тухай мэдээллийг нууцлах нь хууль ёсны шалтгаантай байж болох ч мөрдөн тагнах үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын талаар мэдээлэл, нийт мөрдөн тагнах үйл ажиллагаагаар хэдэн хүнийг тагнасан тухай статистик мэдээллийг нийтэд мэдээлэх ёстой. Тухайн байгууллагуудын албан тушаалын эрэмбэ, бүтэц, шийдвэр гаргах аппарат болон тэдний үйл ажиллагаанаас үүдэх хувийн нууц болон хүний эрхийн асуудлуудыг шинжилсэн байдлыг нийтэд мэдэгдэх үүрэг хүлээх ёстой. Эдгээр бичиг баримтаас тодорхой өгүүлбэр, нэрс гэх мэт зарим зүйлийг харлуулж, нууцлах хэрэгцээ байж болох ч бүхэлд нь эдгээр бичиг баримтыг нийтээс нууцлах ёсгүй. Төр захиргааны бусад байгууллагын адил мэдээллийг ил

тод болгох, төсвийн талаарх мэдээлэл ил байх нь эдгээр мөрдөн тагнах мандат бүхий байгууллагуудын үүрэг байх ёстой.

Хэлэлцүүлэг: Ил тод байдлыг хангах эдгээр хэм хэмжээ нь Монголын хувьд хэрэгжүүлэх боломж хэр вэ? Ямар зүйлс дээр мэдээллийн хүртээмж бий болж, ямар зүйлс дээр хүртээмжгүй байсаар байх бол?

- Гуравдугаарт, мөрдөн тагнах үйл ажиллагааг мониторинг хийх зохистой буюу хараат бус, үр дүн бүхий механизмыг үүсгэх нь чухал. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлж буй хаана ч зохистой мониторинг хийгдэх ёстой ба энэ нь хүний эрхийг хязгаарлаж буй нөхцөлд ялангуяа чухал. НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар асан Нави Пиллай хэлснээр “хараат бус, хөндлөнгийн мониторинггүйгээр дотоод дүрэм, баталгаажуулалт мөрдөн тагнах үйл ажиллагааг буруугаар ашиглахыг зогсоодоггүй”. Мөрдөн тагнах үйл ажиллагааг хараат бус институцын байдлаар хөндлөнгөөс хянах шаардлага нь эдгээр үйл ажиллагаа тодорхойлолтоороо нууцаар хийгддэгээс үүдэн энэ талаар мэдээлэл нь нийтэд хязгаарлалттай байдагтай холбоотой.

- *Жишээ:* 2015 оны хамтарсан тунхаглалын 8(d)-д заахдаа:

Мөрдөн тагнах үйл ажиллагааны тогтолцоонууд болон эдгээрийг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагуудад хараат бус, хөндлөнгийн хяналт тавих ёстой.

- Хяналтын байгууллагуудын тагнуулын байгууллагууд болон гүйцэтгэх засаглалаас хараат бус байдлыг хангах нь амин чухал. Улс орнууд шүүх засаглал, парламентын хяналтын хороод, төрөлжсөн захиргааны хяналтын байгууллага болон иргэний нийгмийн байгууллагууд гэх мэт олон механизмаар дамжуулан хараат бус хяналтыг хэрэгжүүлдэг. Эцсийн дүндээ мөрдөн тагнах үүрэг бүхий байгууллагууд ард түмнээс сонгогдсон төлөөлөгчдөд тайлагнах хариуцлагыг үүрдэг ч ийм хяналтын механизмын бат бөх байдлыг хангахад нэг болон түүнээс дээш төрөлжсөн захиргааны хяналтын байгууллагыг багтаах хэрэгтэй байдаг. Хяналтыг хэд хэдэн байгууллага явуулах үүрэг хүлээсэн бол хяналт хийх хариуцлагыг сэдэвчилсэн байдлаар үүрэгжүүлэх нь агентлаг бүрийг өөр өөр хяналтын механизмаар хянахаас илүү сайн шийдэл болдог.
- Мөрдөн тагнах үйл ажиллагааг буруугаар, зохисгүй ашиглахгүй байхыг хангах өөр нэг арга нь мөрдөн тагнах ажиллагааг урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр хийх арга байдаг. Ихэнх улс орнууд энэхүү аргыг хэрэглэдэг ба зөвхөн зайлшгүй яаралтай тохиолдолд урьдчилсан зөвшөөрөлгүй мөрдөн тагнах ажиллагааг хэрэгжүүлдэг.

Хэлэлцүүлэг: Монголд мөрдөн тагнах үйл ажиллагааг хараат бус, хөндлөнгөөс хянах тогтолцоог үүсгэх боломж бий юу? Тийм бол яагаад, үгүй бол яагаад?

- Дөрөвдүгээрт, мөрдөн тагнах үйл ажиллагааг үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах зайлшгүй шаардлагатай гэж үзэх тодорхой шалгуурыг хангасан тохиолдолд л хэрэгжүүлнэ. “Зайлшгүй шаардлага” гэдэг нь мөрдөн тагнах үйл ажиллагаа хууль ёсны зорилтыг биелүүлэх цорын ганц боломж эсвэл хууль ёсны зорилтыг биелүүлэх хэд хэдэн арга замын дотор мөрдөн тагнах ажиллагааны объектын хувийн орон зайд нэвтрэхдээ хамгийн бага хохирол учруулах арга байх гэх мэт тохиолдлыг хэлнэ.
- Зайлшгүй шаардлагын өөр нэг бүрэлдэхүүн хэсэг нь нийтийн дэг журам, аюулгүй байдлыг хангахын давуу талыг мөрдөн тагнах үйл ажиллагаанаас үүсэх илт бус, шууд бус хэлбэртэй гэм хорыг үнэлэн харьцуулах буюу эдгээрийг тэнцүүлэх. Мөрдөн тагнах үйл ажиллагаа нь хүмүүсийн үзэл бодлоо илэрхийлэх, үүний тулд тодорхой арга замуудыг хэрэглэх хүсэлд шууд нөлөөлдөг нь бодит ба үүнийг нухацтай авч үзэх ёстой.
- Снөөдэний илчилсэн нийтийг мөрдөн тагнах хөтөлбөрүүд нь хувийн нууц болоод үзэл бодлоо илэрхийлэх асуудлаар олны эгдүүцлийг хүргэсэн нь нууц биш. Нөгөө талаас нийтийг хамарсан мөрдөн тагнах үйл ажиллагааны ашиг тус, үүнд зарцуулагдаж буй хөрөнгө төсвийн асуудал, эдгээр нь эцэстээ аюулгүй байдлын агентлагуудын хийх ёстой үндсэн ажлаас нь цаг, анхаарлыг хумсалж буй тухай асуудлууд ч яригддаг.
- Зайлшгүй шаардлагын хэм хэмжээ нь одоо хэрэгжиж буй мөрдөн тагнах олон үйл ажиллагааны объектгүй байдал нь хууль ёсны бус байгааг, оронд нь улс орнууд тодорхой гэм хорын эрсдэл үүссэн тохиолдлуудад энэхүү үйл ажиллагааг хийх ёстойг харуулдаг. “Таван нүд” хөтөлбөрөөс арай бага хувийн орон зайд халддаг өгөгдлийг нийтэд нь хадгалах хөтөлбөрүүд ч объектгүй утгаараа гэм хорын сорилтыг давдаггүйг Европын шударга ёсны шүүх Өгөгдөл хадгалах тогтоолыг хүчингүй болгохдоо тэмдэглэсэн.
- 2015 оны хамтарсан тунхаглал энэ асуудлыг 8(a) ба (b) хэсэгтээ мөн хэсэгчлэн хөндсөн:

Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлахдаа хэрэглэх ёстой гурван шалгуурыг авч үзэхдээ, ялангуяа ийм шалгуурыг хангах ёстой гэсэн шаардлага нь мөрдөн тагнах үйл ажиллагааг тодорхой объект дээр, тодорхой хязгаартай хугацаанд хийгдэх ёстой ба аюулгүй байдлыг хангах, хууль сахиулах болон үзэл бодлоо илэрхийлэх, хувийн нууцыг хүндэтгэх асуудлыг тэнцүүлэх ёстой зарчимд тулгуурладаг. Объектгүй буюу нийтийг хамарсан мөрдөн тагнах үйл ажиллагаа нь мөн чанараараа тэнцвэрийн шалгуурыг хангахгүй ба хувийн нууц, үзэл бодлоо илэрхийлэх эрхэд халдаж буй явдал юм.

Үүнтэй адилаар хууль сахиулах эсвэл аюулгүй байдлыг хангах нэрийдлээр хувь хүмүүсийн мэдээллийг ялгалгүй хадгалах шаардлага нь хууль бус. Хувь хүмүүсийн мэдээллийг хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах хэрэгцээ болон хувийн нууц, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нь харгалзаж үзэн, тэнцвэржүүлэх хэлбэрээр зөвхөн тодорхой объект дээр, тодорхой хязгаартай цаг хугацаанд хадгалбал зохино.

- Эцэст нь хувь хүмүүс өөрийн нэрийг нууцлах, шифрлэлт хийх ямар ч хэрэгслийг ашиглах эрхтэй байх ёстой. Онлайн үзэл бодлоо нууцаар илэрхийлэхийн ач холбогдлыг Европын зөвлөлийн Харилцаа холбооны эрх чөлөөний тухай тунхагаар мөн хүлээн зөвшөөрсөн:

Онлайн мөрдөн тагнах үйл ажиллагаанаас хамгаалах, үзэл бодлын болон илэрхийллийн эрх чөлөөг хамгаалахын тулд (...) интернэтийн хэрэглэгчид өөрсдийн хэн гэдгээ нуух эрхийг нь улс орнууд хүндэтгэвэл зохино.

- 2015 оны Хамтарсан тунхагийн 8(е)-р зүйлд үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг эдлэхдээ нэрээ нууцлах эрхтэй талаар тусгай олон улсын үүргүүд бий тухай мөн дурдсан:

Онлайн нэрээ нууцлах, шифрлэлт ашиглах нь үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхийг нөхцөлдүүлдэг ба энэ утгаараа эдгээрийг хорих, хязгаарлах ёсгүй ба зөвхөн гурван шалгуур бүхий хүний эрхийн зарчмыг хангаснаар эдгээрийг хязгаарлах боломжтой.

Хэлэлцүүлэг: Эдгээр зарчмууд бодитой юу, хэт идеаллаг байна уу? Монголын тагнуулын албад эдгээр зарчмын заримыг нь эсвэл бүгдийг нь хүлээж авна гэж бодож байна уу? Алийг нь хүлээж авах бол? Аль нь хүлээж авахад хүнд байх бол?

Ном зүй

1. Тоби Мендел, “Илэрхийллийг хорих нь: үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө ба нэр төрд халдах эрүүгийн зохицуулалт” (“19-р зүйл”, Лондон хот, 2004). Дараах холбоосоор бий: <http://www.article19.org/data/files/pdfs/conferences/criminal-def-eu-ngo-paper.pdf>
2. Майкл Караниколас, “Цахим орон зайн аяллын хөтөч: мөрдөн тагнах үйл ажиллагаа ба олон улсын хэм хэмжээ” (“Глобал цахим түншүүд”, Лондон хот, 2014). Дараах холбоосоор бий: <http://www.law-democracy.org/live/wp-content/uploads/2012/08/Travel-Guide-to-the-Digital-World-Surveillance-and-International-Standards.pdf>
3. CitizenLab, “Зөвхөн тэдний нүдэнд зориулав: цахим мөрдөн тагнах ажиллагааг арилжааны мөн чанартай болгосон нь” (2013). Дараах холбоосоор бий: <https://citizenlab.org/storage/finfisher/final/fortheireyesonly.pdf>.
4. Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих асуудлаарх Тусгай илтгэгчийн улс орнуудын засгийн

газрууд харилцаа холбоог тагнан мөрдөж байгаа нь хувийн нууцтай байх болон үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх, эрх чөлөөнд нөлөөлж байгаа талаар НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлд 2013 оны тайлагнасан. Дараах холбоост бий: <https://documents-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G13/133/03/PDF/G1313303.pdf?OpenElement>

Хувийн нууцын талаар дүрүүдэд тоглох дасгал

Модуль 5: Цахим орон зайн асуудлууд

Хэлэлцүүлэг: Монголд цахим орон зайд үзэл бодлоо илэрхийлэхэд тулгарч буй гол асуудал юу вэ? Онлайн үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг гэм хор хүргэх үг онлайн илүү ихсэж байгаа нөхцөлд хэрхэн тэнцвэржүүлэх вэ?

- Олон улсын хуулийн дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь холбоо харицлааны бусад хэрэгсэлтэй адил интернэтэд ч хамаардаг нь тодорхой.
- Тодорхой бус байсаар байгаа зүйл нь интернэтийн хүртээмж хүний эрх гэж олон хүмүүс маргасан ч энэ нь эрх мөн эсэх тухай асуудал байгаа. Интернэтийн хүртээмж нь хүний эрх мөн эсэх тухай асуудал мөн чанарын хувьд интернэт үзэл бодлоо илэрхийлэх арга хэрэгслээр барахгүй бусад олон эрхийг нөхцөлдүүлдэгтэй холбоотой үүссэн.
- Бусад хүний эрхийг нөхцөлдүүлэгч интернэтийн үүрэг нь үүнийг уян нийгмийн зэмсэг болгодог. Интернэт нь худалдаа, худалдан авалт, нийгэмших, болзох, соёл ба энтертэймент, албан болон албан бус боловсрол олох, улс төрийн мэтгэлцээн, оролцоо, шашны болон оюун санааны эрэл хайгуул, анагаахын мэдээлэл, бараг бүх салбарын хувьд мэргэжил дээшлүүлэх үндсэн форум болжээ. Товчхондоо олон хүний хувьд интернэт нь тэдний амьдралын өдөр тутмын асуудлыг өөрчилсөн.
- Хэвлэл болон өргөн нэвтрүүлэг гэх мэт бусад бүх шинэ технологийн нэгэн адил олон хүн энэхүү шинэ харилцаа холбооны шинэ арга хэрэгслийг зохицуулах ёстой юу, тийм бол хэрхэн зохицуулах талаар асууж байна.
- Интернэт нь хүүхдийн порнографи гэх мэт гэм хор хүргэхүйц, хууль бус материал тараахад ашиглагддаг нь гарцаагүй үнэн. Гэвч хэвлэмэл эсвэл өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийг зохицуулах зохицуулалтыг интернэтийн хувьд ашиглах нь үр дүнгүй.
- Интернэтийн зохицуулалт нь олон шинэ сорилтуудыг үүсгэж байна. Жишээ нь интернэт ашиглахдаа нэрээ нууцлах боломжтой мөн чанар, онлайн явагддаг нээлттэй хэлэлцүүлгүүдэд нэрээ нуун оролцохын ач холбогдол, эдгээрт хөндлөнгөөс оролцох механизмууд интернэтээр үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг зөрчиж, чөлөөт илэрхийллийг хязгаарладаг. Интернэтийн глобал мөн чанар мөн эрх зүйн харьяаллын бэрх асуудлуудыг үүсгэдэг. Интернэтээр мэдээлэл хуваалцах хялбар байдал нь оюуны өмчийн уламжлалт зохицуулалтыг мөн сорьж байна. Интернэт нь түгээмлээр хүн бүрт хүртээмжтэйгээрээ бусад арга хэрэгслээс ялгаатай. Зөвхөн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдэлдэг хэмээх алдартай үг ч үнэн байхаа больсон. Үүнтэй холбоотойгоор олон нийтийн хэлэлцүүлгийн шинэ, ардчилсан хэлбэрүүд (цахим олон нийтийн талбай)-ийг ч интернэт дэмжиж байна. Ардчилсан орнуудад эдгээр орон зайг хэвээр хадгалахын ач холбогдлыг авч үзэхдээ зохицуулалттай тохиолдолд эдгээр орон зайны үүргээ гүйцэтгэсээр байх эсэхийг бодох шаардлага үүсээд байна.

Хэлэлцүүлэг: Интернет хэрхэн үзэл бодлоо илэрхийлэх арга хэрэгсэл болдог вэ? Сайныг ч, мууг ч авчирсан гэж боддог уу? Интернетийг илүү сайн зохицуулах ёстой гэж бодож байна уу?

1. Интернетийн бүтцийн зохицуулалт

- Интернет нь уламжлалт хууль, эрх зүй болон харьяаллын ойлголтуудад тохирохдоо тааруу. Интернетийн жинхэнэ үнэ цэнэ нь түүний хил хязгаарт баригддаггүй мөн чанартай, нэг секундэд дэлхийн нэг өнцгөөс нөгөө өнцөг рүү үзэл бодлыг тархааж болдгоос ургадаг. Харилцаа холбооны бусад хэлбэрийг бодвол интернет жинхэнэ ёсоор глобал мөн чанартай. Онлайн нөхцөлд үндэсний хил хязгаарын тухай яриа утгагүй болдог. Интернет нь зохицуулалтгүй, хуульгүй газар байх ёсгүй ч, интернетийн хөгжлийн нэгэн тал нь интернетийн олон улсын мөн чанар, шинжийг нь хадгалах үүднээс ямарваа зохицуулалтын тогтолцоонуудыг уялдуулах асуудал байдаг.
- Улс орнуудын хоорондох соёлын ялгаа нь ямарваа нэг зүйлд өөр өнцгөөс хандах хандлагыг зөвтгөх үндэслэл болдог байсан бол интернетийн түгээмэл мөн чанар нь ихэнх тохиолдолд үндэсний хэмжээнд улс орнууд өөрсдийнхөөрөө зохицуулах гэж оролдох нь гэм хор хүргэхүйц, мөн үр дүнгүй болгодог. Учир нь интернет уламжлалт газар нутгийн, эрх зүйн харьяаллаас тасарсан. Нэг улс орон интернетийн тодорхой зүйлийг хориглосон ч ихэнхдээ тодорхой хэмжээний техникийн мэдлэгтэй хүмүүс түүнийг нь янз бүрийн байдлаар тойроод гарчих боломжтой зүйлс байдаг. Гэвч иймэрхүү оролдлогууд интернетийн эрх чөлөөг боомилох утгаараа гэм хортой. Учир нь интернетийг чадан ядан зохицуулах гэсэн нь хувирамтгай хууль, эрх зүйн орчин бүрдүүлдэг ба хүн бүрийн техникийн мэдлэгээс шалтгаалан өөр өөрөөр хүртээмжийн хэм хэмжээг үүсгэдэг. Хил хязгааргүй онлайн орон зайд улс орны хил хязгаарын дотор ажилладаг хэм хэмжээ тохиромжгүй ба ийм нөхцөлд бүхэлдээ интернетийн хөгжилд сөргөөр нөлөөлөх боломжтой.
- Интернетийн зохицуулалт үндсэн хоёр түвшинд явагддаг ба энэ нь глобал хэмжээнд болон улс орны хэмжээнд. Глобал интернетийг байнгын ажиллагааг нь хангах гэх мэт шалтгаанаар зохицуулах шаардлага бий. Харин зарим улс орнууд бусад өөр шалтгаанаар үндэснийхээ хэмжээнд интернетийг зохицуулахыг оролддог.

Олон улсын зохицуулалт

- Top-level domain (TLD) буюу дээд түвшний домэйн нэр олгох (улс орны өргөтгөл болон .com, .org), нөөцийг дугаарлах, интернетийн ажиллагааг хангадаг техникийн протоколуудыг хуваарилах гэх мэт шалтгаанаар олон улсын зохицуулалт хийгдэх шаардлагатай байдаг.
- Энэ болгоныг Нэр ба дугаарын интернетийн корпорац (Internet Corporation for Assigned Names and Numbers ICANN) нэртэй Калифорнид байрлах ашгийн бус байгууллага гүйцэтгэдэг. Энэ талаар НҮБ-ын Мэдээллийн нийгмийн дэлхийн чуулганаас үүсгэсэн Интернетийн засаглалын форум гэх засгийн газрууд, иргэний нийгмийн байгууллагууд,

- хувийн хэвшлийнхнээс бүрдсэн форум хэлэлцүүлгүүд өрнөсөөр байна.
- Интернэт гэсэн ийм амин чухал эх сурвалжийг нэг улсад харьяалагддаг ашгийн бус байгууллага ажиллуулах ёстой эсэх талаар, НҮБ-ын Олон улсын харилцаа холбооны холбоо, эсвэл ЮНЕСКО-ийн мандатад багтаах эсэх талаар хэлэлцүүлгүүд өрнөсөөр байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөний асуудлаар ажилладаг олон байгууллага, хүмүүс НҮБ-д харьяалуулах асуудал дээр ноцтой асуудлууд үүснэ гэж айдаг. Нөгөөтэйгүүр ICANN-ыг илүү олон улсын мөн чанартай болгох үйл ажиллагаа хийгдсээр байна.
 - Олон улсын түвшинд хийгддэг ихэнх зохицуулалт нь нэлээд техникийн шинж чанартай байдаг ч хэрэглэгчдийн хувьд чухал асуудлуудыг үүсгэдэг. Энэхүү байгууллагын зарим шийдвэр үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөнд шууд халтай байдаг. Жишээ нь хэдэн жилийн өмнө порнографид зориулсан .xxx гэсэн шинэ дээд түвшний домэйн үүсгэх хөдөлгөөн өрнөсөн. Энэ саналыг боловсруулсан хүмүүс нь порнографи нь интернэтэд тэртээ тэргүй хаа сайгүй байгаа тул нэг л газар цуглуулвал хүсээгүй хүмүүс нь тийш орохгүй гэсэн. Харин зарим хүмүүс порнографид дээд түвшний домэйн олгох нь ямар нэг байдлаар дэмжсэн болно гээд энэхүү дээд түвшний домэйнийг үүсгээгүй.

Хэлэлцүүлэг: Энэ талаар юу бодож байна? Интернэтийг ардчилснаар засаглах, ардчилал хөгжөөгүй орнуудад энэхүү глобал нөөцийг зохицуулах гэж оролдож буйг хэрхэн тэнвэржүүлэх боломжтой вэ?

Интернэтийн төвийг сахих зарчим

- Дэлхий даяар өргөнөөр хэлэлцдэг интернэтийн зохицуулалтын нэг асуудал бол интернэтийн төвийг сахих зарчим юм. Үндсэндээ энэ нь улсын болон олон улсын хэмжээнд явагддаг мэдээллийн урсгал чөлөөтэй урсах ёстой гэсэн асуудал. Өндөр нягтаршил бүхий видео үзэх, томоохон файл татаж авах гэх мэт интернэтийн хурд шаардах үйл ажиллагаа ихсэх тусам интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын нөөц илүү шаардагдаж, бусад хэрэглэгчдийн хувьд интернэт ашиглах хурд саарахыг зохицуулахтай холбоотой үүссэн асуудал юм.
- Интернэтийн эрх чөлөөг хөхиүлэн дэмжигсэд интернэтийн төвийг сахих зарчмыг дэмждэг. 2011 оны Тунхаглалдаа Тусгай илтгэгчид хэлэхдээ:

Интернэтийн өгөгдөл болон урсгалыг хэрэглэгчийн төхөөрөмж, агуулга, зохиогч, агуулгын эх үүсвэр болон хүрэх цэг, үйчилгээ болон эдгээрийг хэрхэн хэрэглэх хэрэглээгээр ялгаварлах ёсгүй.

- Хэдий тийм ч ялгавартай асуудлууд үүссээр байгаа нь интернэтийг зохицуулагч техникийн ажиллагааны протоколууд зарим өгөгдлийг буюу өгөгдлийн урсгалыг зохицуулсан зохицуулалт кодуудыг илүү чухалчилж байгаатай холбоотой (замын хөдөлгөөн илүү байгаа газарт гэрэл дохиог илүү чухалчилдагтай адил).
- Энэхүү өгөгдлийн “бөглөрөл” үүсэж байгаа хэмээх асуудлыг шийдвэрлэх

хэд хэдэн сонирхолтой шийдлүүдийг дэвшүүлсэн байгаагаас өгөгдлийн багц хэр урт зам туулж буйгаар төлбөр тооцох, интернэтийн хурдыг эсвэл зарим үйлчилгээг илүү ашигладаг хэрэглэгчдийн хэрэглээний хурдыг хязгаарлах, хамгийн их шүүмжлэгддэг шийдэл болох өгөгдлөө хурдан явуулах хүсэлтэй хэрэглэгчид илүү төлбөр төлснөөр бага төлбөр төлж буй хэрэглэгчдээс хурдан өгөгдлөө явуулах шийдэл гэх мэт үүнд багтаж байна. Эдгээр саналыг интернэтийн төвийг сахих зарчим буюу бүх урсгал ялгаваргүй хурдтай дамжих ёстой гэсэн зарчимд харш хэмээн шүүмжлэгддэг.

- Энэхүү зохицуулалтын асуудалд улс орнууд хэд хэдэн байдлаар хандсан:
 - *Жишээ:* 2010 оны 7-р сард Чили Улс интернэтийн төвийг сахих зарчмыг албан ёсоор хуульчилсан эдлэхийн анхны улс болсон. 2010 оны 6-р сараас 10-р саруудын хооронд Европын холбоо интернэтийн төвийг сахих зохицуулалт дээр олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан ч энэ асуудлаар хууль дүрэм гаргахаас татгалзахаар шийдсэн нь интернэтийг чөлөөтэй, нээлттэй байхыг хангахад ил тод байдал болон хэвлэл мэдээллийн мониторинг хангалттай гэж үзсэнтэй холбоотой.
 - *Жишээ:* Интернэтийн төвийг сахих зарчмын талаарх улстөржсөн асуудал АНУ-д үргэлжилсээр байгаа ч одоогийн байдлаар Холбооны харилцаа холбооны комиссын “Интернэт нээлттэй байх тушаал” энэ асуудлын зохицуулалт болж байна. Энэхүү тушаалын гурван үндсэн дүрэм нь сүлжээний зохицуулалтын үйл ажиллагааны зарчмууд нээлттэй байх, хууль ёсны агуулгыг блоклохыг хориглох дүрэм, хууль ёсны агуулгыг зөвтгөж үл болом байдлаар (“сүлжээний зохицуулалтын шаардлага”-аас хэтэрсэн байдал) ялгаварлахыг хориглох дүрэм юм. Энэхүү тушаалын нарийн утга тодорхой бус хэвээр байдаг ч тушаалын тайлбарт зарим өгөгдөл урсгалын зохицуулалтаар бусад хэрэглэгчдийн хэрэглээг хязгаарлаж буй хэт ачаалал үүсгэдэг хэрэглэгчдийн өгөгдөл урсгалын бөглөө үүсэхээс урьдчилан сэргийлэх, түүнийг багасгах зохицуулалтын ажиллагаа нь шаардлагатай ч, өгөгдлийг базах, хязгаарлах өргөн арга хэмжээ болон өгөгдлөө эн тэргүүнд илүү төлбөрийн үндсэн дээр дамжуулах явдлыг зөвшөөрөхгүй гэсэн зарчмыг багтаасан гэж үздэг.
- Энэ асуудлыг зохицуулах хамгийн тохиромжтой хэлбэр нь интернэт хүртэх нь хүний эрх хэмээх томъёололд үндэслэж, интернэтийн хүртээмжийн хамгийн шилдэг, түгээмэл аргын загвар боловсруулах асуудал. Интернэтийн хүртээмжийг төлбөрийн чадвараар шатчилсан байдлаар тогтоох ёстой гэсэн саналыг дэмжигсэд шатчилсан өгөгдөлтэй холбоотой хуримтлагдах илүү төлбөрийн сан интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын үндэс болж, ингэснээр бусад бүх хэрэглэгчдэд интернэт илүү хурдан болно гэж үздэг. Хэдий тийм ч интернэт нь хүний эрх юм бол ядуу хүмүүс онлайн ертөнцөөс төлбөрийн чадвараараа шахагдахад хүргэх, эсвэл хөдөө орон нутагт, ямарваа байдлаар тэгш бололцоогүй хүмүүсийн

интернэтийн холболтын хурд болон хэрэглээг багасгахад хүргэх ямар ч загварыг хүлээн зөвшөөрөх ёсгүй.

- Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд олон оронд өөр өөр үнээр өөр өөр үйлчилгээ үзүүлж, төлбөр илүү төлж буй хүмүүст өндөр хурд санал болгож байгаа нь бодит байдал. Эдгээр компаниуд хурдан холболт, илүү өгөгдөл дамжуулах үйлчилгээндээ илүү төлбөр авч байгаа.
- 2011 оны хамтарсан тунхаглалд Тусгай илтгэгчдийн хэлсэн:

Интернэтийн үйлчилгээг хүргэж буй этгээдүүд өөрсдийн хэрэглэдэг мэдээлэл болон өгөгдлийн урсгал зохицуулалтын арга хэлбэр болон хамаарал бүхий мэдээллийг холбогдох бүх талуудад хүртээмжтэй хэлбэрээр нээлттэй байлгана.

Хэлэлцүүлэг: Интернэтийн бүтцийн зохицуулалт байх ёстой гэж бодож байна уу? Зохицуулалт ямар зорилгыг агуулах ёстой вэ? Хэрхэн хэрэгжих бол?

Үндэсний зохицуулалт

- Интернэтийн үндэсний хэмжээн дэх зохицуулалт шаардлагатай байдаг хэд хэдэн салбар байдгаас үндэсний домэйн нэрийн зохицуулалт. Нөгөө талаар үндэсний зохицуулалт хэрэгцээ шаардлагаас хэтэрдэг нь бий.

Домэйн нэр

- Улс бүрт тухайн улсын кодын дээд түвшний домэйн нэр, өргөтгөл олгогдсон байдаг ба үүнийгээ зохицуулах үүрэгтэй. Монголын хувьд энэ нь .mn. Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөнд нөлөөлж буй бүх зохицуулалтын ажиллагаа нь хараат бус институцээр дамжин хийгдэх ёстой гэсэн олон улсын зарчим байдаг нь улсын домэйн нэр бүртгэлд мөн хамаардаг.
- Улсын домэйн нэр бүртгэлийг ашгийн төлөө бус байгууллага эсвэл засгийн газраас хараат бус өөр зохицуулалтын байгууллага зохицуулах нь сайн жишиг. Харамсалтай нь ихэнх улсад домэйн нэрийн бүртгэл ба зохицуулалтыг яам эсвэл аливаа төрийн байгууллага шууд зохицуулдаг.
- Ингэх нь үндэсний домэйн нэрийн хөгжилд саад учруулж, иргэдэд томоохон сөрөг нөлөөтэй. Жишээ нь, засгийн газрын шууд зохицуулалтад байх тохиолдолд үндэсний хэл дээрх улсын домэйн өргөтгөл бүхий агуулга дэмжигддэггүй. Монгол Улсын хувьд эх хэл дээрх мэдээлэл онлайн их байх нь чухал асуудал байх.
- Интернэтийн нээлттэй мөн чанар нь улс орнууд үүнийг домэйн нэрээр зохицуулах боломжгүй гэсэн үг. Улсын нэр бүхий өргөтгөлтэй вэбсайтаа бүртгүүлж чадахгүй хэн ч олон улсын .com эсвэл .org өргөтгөлтэй домэйн нэрийг сонгох боломжтой. Ингэснээр урт хугацаанд улсын өргөтгөл бүхий домэйн нэрний зохицуулах нь ихэнх хэрэглэгч үүнийг сонгохоо болих аюулыг дагуулдаг. Мөн улсын өргөтгөл бүхий домэйн нэрийн бүртгэлд хэт их төлбөр хурааж буй нөхцөл ч ижил үр дүнд хүргэнэ (олон улсын домэйн нэрүүдийн жилийн төлбөр нь 10 ам.доллар).

Хэлэлцүүлэг: Монголд домэйн нэрийг хэрхэн олгож, зохицуулдаг вэ? Энэ тогтолцоо нь хангалттай юу эсвэл монгол хэрэглэгчид .org эсвэл .com-ыг сонгож байна уу?

Бусад үндэсний бүтцийн зохицуулалтын асуудлууд

➤ Зарим хүмүүс интернэтийг өргөн нэвтрүүлэг, (зарим улсын нөхцөлд) сонин сэтгүүлийн нэгэн адил лицензжүүлэх ёстой гэж үздэг. Үүнийг хийх хэд хэдэн боломж бий. Зарим улс оронд вэбсайт, эсвэл тодорхой вэбсайтуудыг, ялангуяа мэдээ, мэдээлэл бүхий вэбсайтуудыг бүртгүүлж, лицензжүүлэх аргыг хэрэглдээг.

▪ *Жишээ:* 2012 онд Иордан Улсад бүх сонинтой адил мэдээллийн вэбсайтууд бүртгүүлж, үйл ажиллагаа явуулах лиценз авах ёстой хууль баталсан. Энэ тогтолцоонд томоохон асуудлууд үүссэн. Нэгт, юуг мэдээллийн вэбсайт гэх нь тодорхойгүй байсан. Хоёрт, иймэрхүү вэбсайтууд тэднийг хянахыг оролдож байна гэж үзээд олон вэбсайт бүртгүүлэхээсээ татгалзсан. Хариуд нь Иорданы засгийн газар 200 вэбсайтыг хаахад эдгээрийн зарим нь гадаад дахь сервер луу вэбсайтаа зөөсөн. Онцлох сөрөг нөлөө нь тухайн улсын онлайн мэдээллийн эх сурвалжийн хөгжил, цаашлаад арчдилалд тун ноцтойгоор нөлөөлж, нийтийн сэтгэл зовоосон асуудлаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх асуудлыг хаасан явдал болсон юм.

➤ Зарим улс орнууд интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниудыг медиагийн бусад төрөлтэй адил үйл ажиллагаа эрхлэхдээ тусгай бүртгэл, тусгай зөвшөөрөл авах ёстой гэсэн шаардлага тавьдаг. Интернэт нь бусад харилцаа холбооны бүх төрлөөс ялгаатай ба бусад төрөлд зориулан боловсруулсан зохицуулалтыг шууд ашиглах боломжгүйг олон улсын хэм хэмжээ сануулдаг. 2011 оныхоо хамтарсан тунхаглалдаа Тусгай илтгэгчид хэлсэнээр:

Утас болон өргөн нэвтрүүлэг гэх мэт бусад харилцаа холбооны хэлбэрүүдийг зохицуулах зохицуулалтыг интернэтэд шууд хэрэглэх боломжгүй ба интернэтэд зориулсан тусгай зохицуулалт боловсруулах шаардлага байна.

➤ Олон улсын хуулийн дагуу үзэл бодлоо илэрхийлэхийг хязгаарлах ямарваа хязгаарлалт нь хууль ёсны үндэслэлтэй байх ёстой. Өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааг лицензжүүлэх нь долгионы үелзэл хязгаартай тоотой байдагтай, мөн ийм өргөн нэвтрүүлэг хийх сонирхол бүхий этгээдүүдийн цөөн нь үүнийг хийх техникийн боломжтой байдагтай холбоотой. Ийм хязгаарлалтын зохицуулалт интернэтийн хувьд хэрэглэх боломжгүй тул лицензжүүлэлт хийх нь хууль ёсны шаардлагыг хангахгүй. Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниудыг бүртгүүлэх, лиценз авахыг тусгайлан зохицуулах нь хууль ёсны бус асуудал болохыг хүлээн зөвшөөрсөн. Ардчилсан орнуудад интернэтээр

буюу вэбсайтуудаар дамжуулан мэдээ, материал түгээх нь ямарваа тусгай зохицуулалттай байдаггүй.

- Зарим оронд засгийн газрууд нь интернэт протоколын (Internet Protocol IP) хаягаа нээх шаардлагыг хүмүүст тавьсаар ирсэн. Энэ хаяг нь интернэтэд холбогдож буй компьютер бүрийн хаяг гэсэн үг. Энэ нь шуудангаар илгээгдэж буй захидал бүр буцах хаягтай байх ёстой гэсэнтэй адил зохисгүй шаардлага ба интернэт протоколын хаягууд тогтмол байдаггүйгээс буюу шинэ байршлаас интернэтэд холбогдох тухай бүрт компьютер шинэ хаягтай болдог тул практик ач холбогдол багатай зүйл.

2. Оюуны өмч ба зохиогчийн эрх

- Онлайн харилцаа холбооны өөр нэгэн зохицуулалтын шаардлагыг үүсгэдэг зүйл нь онлайн дахь оюуны өмчийн хамгаалалт. Оюуны өмч эзэмшигчид өөрийн өмч, өмчөө хамгаалах хууль ёсны ашиг сонирхолтой байдаг хэдий ч хэд хэдэн улс орнууд онлайн “дээрмийн” асуудлыг хэт хүнд зохицуулсан зохицуулалтыг боловсруулах, хэлэлцүүлэх, хэрэгжүүлэх шатандаа явж байна.
- Онлайн дээрмийн нэгэн нийтлэг зохицуулалт нь “мэдэгдэл хүргүүлэх, хаах” арга байдаг ба үүнийг АНУ-ын “Цахим мянганы зохиогчийн эрхийн тухай хууль” (Digital Millennium Copyright Act DMCA), эсвэл Европын холбооны “Цахим худалдааны тогтоол”-оос харж болно. Үндсэндээ “мэдэгдэл хүргүүлэх, хаах” тогтолцоо нь агуулгыг байршуулагчийг байршуулагчаас тусдаа хэрэглэгчийн оюуны өмчид халдсан үйлдлийн төлөө хуулийн хариуцлага хүлээлгэхгүй байх зорилготой. Ингэхдээ тухайн зохиогчийн эрхэд халдсан материалын тухай мэдэгдэл хүлээж авсны дараа шуурхай мэдээллийг устгасан тохиолдолд хариуцлага хүлээлгэхгүй байхаар зохицуулсан. Практик хэрэглээний хувьд “Цахим мянганы зохиогчийн эрхийн тухай хууль”-ийн процедур нь зохиогчийн эрхийг эзэмшигч өөрийн өмчийг онлайн байгааг мэдсэн тохиолдолд тухайн агуулгыг байршуулсан байгууллагад тухайн материалыг хэрхэн өөрийн агуулгаас олох, таних тухай мэдээлэл, тухайн өмчийг хууль ёсоор ашиглах эрх тухайн байршуулагчид байхгүйг сануулах, тухайн өмчийг өөрийн эсвэл оюуны өмчийн эзний өмнөөс тухайн өмчийг өөрийн мэт захиран зарцуулах эрхтэйг заасан мэдэгдлийг явуулдаг. Тухайн мэдэгдлийг авснаар агуулга байршуулагч материалыг буулгахдаа тухайн зөрчил гаргасан этгээдэд тухайн материалыг дээрх шалтгаанаар буулгаж, арилгасан тухай мэдэгдлийг өгдөг.
- “Мэдэгдэл хүргүүлэх, хаах” тогтолцоо нь оюуны өмчийн тухай асуудлыг зохистой шүүхийн процессгүй агуулга байршуулагчийн эрх мэдэлд үлдээж буйг хүмүүс шүүмжилдэг. Хуулийн хариуцлага хүлээхгүй байх нь тэд хэр хурдан мэдэгдлийн дагуу арга хэмжээ авч буйтай, мөн хариуцлага хүлээхийг хүсдэггүйтэй нь холбоотой агуулгын байршуулагчид тухайн оюуны өмчид халдсан гэх гомдол нь үнэн эсэхийг нарийн шалгадаггүй, тухайн оюуны өмчийг хэрэглэх хууль ёсны хүрээнд тухайн материалыг ашиглах эсэхийг шинжилдэггүй. Хууль, эрх зүйн үүднээс тэдний хувьд ямарваа ирсэн бүх мэдэгдлийг хэрэгжүүлэх нь

илүү аюулгүй. “Цахим мянганы зохиогчийн эрхийн тухай хууль”-иар хуурамч мэдэгдэл хүргүүлсэн тохиолдолд тухайн мэдэгдлийг авсан хэрэглэгч агуулгыг устгах тухай байршуулагчийн шаардлагыг хүлээж авсан, мөн асуудлыг холбогдох шүүхийн байгууллагаар худал үнэн болгохыг шалгуулан тогтоолгохыг зөвшөөрч буй “эсрэг мэдэгдэл” гаргах эрхийн механизмыг багтааж өгсөн байдаг. Хэрэв оюуны өмчийн эзэн энэхүү эсрэг мэдэгдэлд 14 хоногийн дотор хариу өгөхгүй бол интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компани тухайн материалыг эргүүлж байршуулах үүргийг хүлээдэг.

➤ Ийм баталгаажуулалтуудыг хангасан хэдий ч “Цахим мянганы зохиогчийн эрхийн тухай хууль”-ийг буруугаар ашигласан олон тохиолдол байна.

- *Жишээ:* 2008 онд Саянтологийн сүмийг төлөөлсөн хэмээх байгууллага YouTube-д 23 цагийн дотор саянтологийг шүүмжилсэн видео бүр дээр 4000 мэдэгдлийг хүргүүлж байсан. Ихэнх хэрэглэгч “эсрэг мэдэгдэл” хүргүүлсэн хэдий ч энэ асуудлыг хянах хугацаанд хэрэглэгчдийн агуулга, зарим тохиолдолд тэдний YouTube-ийн дансыг хаасан явдал гарсан. Саянтологийн сүм “Цахим мянганы зохиогчийн эрхийн тухай хууль”-ийг ашиглах Гүүл-ийг зарим шүүмжлэл бүхий вэбсайтуудыг хайлтын жагсаалтаас арилгахыг шаардаж, санасандаа хүрсэн. Эволюцийн онолын эсрэг загалмайтнууд эсэргүүцэгчдээ дууг нь хорих ижил арга ашигладаг. АНУ-ын Калифорнийн хойд дүүргийн мужийн шүүх 2008 онд Universal Music Corporation нь “Цахим мянганы зохиогчийн эрхийн тухай хууль”-ийг буруугаар ашиглан YouTube-д байршуулсан байсан видеог буулгуулсан талаар дүгнэлтэд хүрч байсан. Тэр видео нь Принсын чанар муутай дууны бичлэг дээр хүүхдүүд бүжиглэж буй видео байсан ба дуу нь зөвхөн 20 секунд л сонсогдож байсан. Ийм байдлаар тухайн хөгжмийг ашиглах нь шударга ашиглалт мөн болохыг шүүх батласан ба хууль ёсны үндэслэлгүйгээр тухайн видеог хаалгах мэдэгдлийг хүргүүлсэн гэж дүгнэсэн.

➤ Мэдэгдэлд хүргүүлэх, хаах аргын шүүмжлэгчид илүү нарийн процедур бүхий тогтолцоог хүсдэг. Ингэснээр хэрэглэгчдийн материалыг буулгахаас өмнө хэрэглэгчид хариу өгөх боломжоор хангагдах юм. Агуулгын эзэд ч одоо хэрэглэгдэж буй тогтолцоог мөн шүүмжилдэг нь процедурыг тэднийг илүү хамгаалсан, хурдан болох ёстой талаар хэлдэг.

➤ Оюуны өмчид халдсантай холбоотой санкц, шийтгэлтэй холбоотой зарим асуудал нь хэрэглэгчдэд интернэт хэрэглэх эрхийг хаах асуудал байдаг.

- *Жишээ:* Францад “Бүтээл ба интернэтийн хууль”-иар оюуны өмчид халдсан явдлыг гурван удаагийн зөрчил гаргасны дараа шийтгэх дүрмээр зохицуулдаг. Годорхой IP хаягийн талаар гурван удаа гомдол ирсэн тохиолдолд интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компани тухайн хэрэглэгчийн интернэт хэрэглэх эрхийг түдгэлзүүлдэг.

Хамгийн чухал нь тухайн хэрэглэгч бусад интернэтийн үйлчилгээ үзүүлдэг бүх компанийн хар жагсаалтад орсноор нэг жил хүртэлх хугацаанд интернэт хэрэглэх эрхгүй болдог. Төстэй гурван зөрчлийн аргыг Өмнөд Солонгост 2009 оныхоо Оюуны өмчийн хуулийг шинэчлэн, хэрэгжүүлж эхэлсэн. Их Британийн 2010 онд батлагдсан “Цахим эдийн засгийн тухай хууль” нь оюуны өмчид халдсан, халдахыг нөхцөлдүүлж буй тохиолдолд тухайн хэрэглэгчийн интернэтийг нь хаанаас ч хаах эрх мэдлийг засгийн газарт олгодог. АНУ-ын “Онлайн дээрмийг зогсоо” хуулийн санаачлага нь оюуны өмчийн эздэд зар сурталчилгааны компаниуд оюуны өмчид халддаг вэбсайтуудтай ажил хэргийн түншлэл үүсгэхийг нь зогсоох шүүхийн мэдэгдэл гаргуулах, хайлт болон домэйн нэр бүртгэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг эдгээр вэбсайтуудыг жагсаалтаас хасах гэх мэт эрхийг олгох байсан. Эдгээр хуулийн заримыг шүүхийн процессоор хүчингүй болгосон бол заримын хэрэгжилтийг түр зогсоосон (жишээ нь Францад).

- Интернэт хэрэглэх нь эрх болох тухай томъёоллын дагуу хувь хүмүүсийн интернэт хэрэглээг бүрэн хаах асуудал нь ноцтой үр дагавартай. Учир нь ийм хязгаарлалт нь үзэл бодлоо илэрхийлэх эрх , эрх чөлөөг хязгаарлах гурван хэсэгт шалгуурыг хууль ёсны дагуу ханган давсан байх ёстой. Шийтгэлүүдийн хатуу мөн чанарыг харахад ямар ч эсвэл тун бага хуулийн процесстэй хийгдсэн интернэтийн хэрэглээг хаахыг зөвшөөрөх арга хэмжээ нь хуулийн дагуу интернэт хэрэглэх эрхээ хэрэглэгч хэрхэн хамгаалж болох тухай маш бага зохицуулалтыг багтаасан ба хууль ёсны хувьд хэтэрсэн арга хэмжээ болдог.
- Оюуны өмчийг дуусгавар болох асуудлыг хэн ч нухацтай хөхиүлэн дэмждэггүй ч өнөөгийн эрх зүйн зохицуулалтын талаар болон хугацааны талаар олон асуудал байгааг хүмүүс заадаг (жишээ нь хугацааны хувьд олон улсын хуулийн дагуу оюуны өмчийн зохиогч нас барснаас хойш 50 жилийн дотор, үндэсний хууль тогтоомжийн хүрээнд түүнээс урт хугацаанд түүний зохиогчийн эрх түүний хууль ёсны залгамжлагчдад хадгалагдах асуудал, хүрээний хувьд жишээ нь Мартин Люүтэр Кингийн “Надад мөрөөдөл бий” нь зохиогчийн эрхээр хамгаалагдсан ба зөвшөөрөлгүй ашиглахыг хориглодог).

Хэлэлцүүлэг: Монголд оюуны өмчийн хуулийг зүй бус байдлаар ашиглах боломжууд юу байх бол? Хуулиар монголын болон гадаадын оюуны өмчийн талаар зааглах шаардлагатай юу? Франц, АНУ болон бусад улсуудад оюуны өмчийг бүтээгчид олон байдаг учир үүнд хэрхэн хандах бол?

3. Агуулгын асуудлууд

- Дээр дурдсанчлан оффлайн харилцаа холбооны хэлбэрт зориулан боловсруулсан дүрмийг интернэтийн харилцаа холбоонд хэрэглэх нь зохимжгүй. Ингэх нь зарим тохиолдолд ноцтой асуудлуудад хүргэдэг. Үүний оронд зарим эрх зүйн зохицуулалтыг интернэтийн тусгай мөн чанарыг харгалзан үүсгэвэл зохино.

Харьяаллын асуудал

- Интернэтийн үндсэн мөн чанарын нэг нь хаана мэдээлэл хэвлэснээс үл хамааран тэр нь бүх дэлхий даяар хэвлэгддэг байдал. Энэ утгаараа интернэтийн хэвлэл нь оффлайн ямар ч хэвлэлээс бүрэн өөр байдаг ба оффлайн хэвлэн нийтлэгч түгээлтийг тодорхой хэмжээгээр хянах боломжтой байдаг. Зарим ном, эсвэл сонин сэтгүүл өргөн газар зүйн түгээлттэй байдаг ба томоохон, алдартай бүтээгдэхүүнүүдийг илүү тодорхой, хяналттай түгээдэг.
- Эрүүгийн хэргүүд дээр газар нутгийн харьяаллын асуудал харьцангуй хөгжсөн байдаг ба тухайн хэрэг хаана үйлдэгдсэн, эсвэл сэжигтний иргэншлийн хуулиар зохицуулагддаг. Нөгөө талаас, нэр төрд халдах гэх мэт иргэний хэргүүд дээр гэм бурууг уламжлалт ойлголтоор “нийгмийн зөв сэтгэгч хүмүүсийн нүдэнд нэхэмжлэгчийг үнэлэх үнэлгээг бууруулсан” гэсэн үндэслэлээр авч үздэг. Энэхүү шалгуурыг гүйцэлдүүлэхийн тулд нэхэмжлэгчийг таньдаг хүмүүс тухайн хэвлэн нийтлэгдсэн зүйлийг уншсан, эсвэл үүний тухай сонссон байх хангалттай байдаг. Иймээс уламжлалт дүрмийн дагуу тухайн нэр төрд халдсан гэх мэдээллийг нэг л хүн уншсан байхад хангалттай хариуцлага үүсэх үндэслэл гэж үздэг. Интернэтээр цацагдсан мэдээллийн хувьд хаана л бол хаана ийм хэргийг үүсгэх боломж бүрддэгээрээ энэ нь асуудалтай.
 - *Жишээ:* Их Британи болон Австрали гэх мэт улсын шүүхүүд газар нутгийн харьяалал сул байх тохиолдолд ч нэр төрд халдсан гэх нэхэмжлэлийг авч үзэхийг зөвшөөрдөг. Нью Йорк хотын уугуул, зохиолч Рэйчел Эхрэнфэлдийн эсрэг хэргийг Саудийн чинээлэг бизнес эрхлэгч Шейх Калид бин Мафууз Их Британид үүсгэсэн. Тухайн зохиолчийн “Бусармагийг санхүүжүүлэх нь: терроризмыг хэрхэн санхүүждэг, үүнийг хэрхэн зогсоох тухай” 23 ном л Их Британид зарагдсан ч Шейхын нэр төрд халдсан асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргасан. Шүүх Бин Махфуузын талд хэргийг шийдэж, тухайн номыг устгах, уучлалт хүсэх, гэм хорыг барагдуулах шийдвэр гаргасан байдаг. АНУ хариуд нь АНУ-ын шүүхүүд АНУ-ын Үндсэн хуульд харш шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх дээр татгалзах эрхийг өгч хариу барьсан. Холбооны түвшинд, жишээ нь, засгийн газар “Үндэсний хуулийн мөнх, тогтсон өвийг хамгаалах тухай хууль” баталснаар үүнийг хийсэн ба Их Британийн хууль ч энэ асуудлын дараа өөрчлөгдсөн.
- Газар нутгийн эсвэл эрх зүйн харьяалал хүчтэй байхыг шаардах нь илүү сайн жишиг болно. 2011 оныхоо хамтарсан тунхгалалдаа Тусгай илтгэгчид ийн үүнийг баталгаажуулсан:

Интернэтийн агуулгад хамаарах нэхэмжлэлийн тухайд тухайн хэрэгт бодит, материаллаг холбоотой буюу тухайн зохиогч тэнд оршин суудаг, тухайн газарт агуулгыг интернэтэд тавьсан, тухайн улс орны засгийн газарт ялангуяа хамаарах асуудлыг тавьсан бол тухайн газар нутгийн засгийн газар шударга ёсыг тогтоох эрхтэй байна. Хувь хүмүүс үнэмлэхгүй гэм хорыг тухайн газар нутагт амссан гэж үзсэн тохиолдолд нэхэмжлэл гаргах эрх эдлэнэ (“нэр төрд халдах асуудлаар жуулчлал хийх”-ийн эсрэг дүрэм).

- *Жишээ:* АНУ-д газар нутгийн харьяаллын асуудлыг Дээд шүүхийн *Калдер Жөүнзийн эсрэг* хэргийн дагуу шийдвэрлэдэг. Дээд шүүх тогтсон “нэхэмжлэгч тодорхой наад захын хэдэн хүмүүс, байгууллагыг таньдаг байх, тухайн нэхэмжлэлийг үүсгэснээр шударга ёс, газар нутгийн харьяаллын асуудлын тухай уламжлалт ойлголтыг эвдэхгүй байх ёстой” гэсэн шалгуурыг баталгаажуулсан. Калифорни нь газар нутгийн хувьд харьяалахыг баталгаажуулахдаа шүүх “Калифорни нь тухайн үйл явдал явагдсан газар мөн ба тэнд хамгийн их гэм хор үүссэн” гэж тэмдэглээд, “тухайн мэдээлэл нь Калифорнийн эсрэг байсан ба хариуцагч этгээдүүд логикоор энд л шүүхэд дуудагдахдаа бэлэн байх ёстой байсан” гэжээ.
- *Бангуура Вашингтон постын эсрэг* хэрэг дээр Канадын Онтариогийн давж заалдах шатны шүүх нэр төрд халдах хэргүүд дээр газар нутгийн харьяаллын асуудлыг хэрхэн шийдэх тухай гол гол дүрмийг тогтоосон. 2000 онд шийдэгдсэн хэргийн нэхэмжлэгч Бангуура 2003 онд Вашингтон пост сонины 1997 онд нийтлэсэн хоёр нийтлэлийнх нь төлөө шүүхэд нэхэмжилсэн. Эдгээр нийтлэлийг төлбөр төлсний үндсэн дээр бүхэлд нь тухайн сонины вэбсайтаас унших боломжтой ба товчлолыг үнэгүй унших боломжтой байсан. Шүүх “бодит, материаллаг холбоо” гэх дүрмийг газар нутгийн харьяаллын асуудлыг шийдэхдээ ашигласан ба хариуцагч нь тухайн нийтлэлүүд гарснаас хойш хэдэн жилийн дараа Онтариод нүүж ирсэн нь тухайн холбоо байгааг батлах хангалттай үндэслэл болохгүй гэж үзээд нийтлэлийн хэвлэгчид нүүхээ тухайн үед мэдэх боломжгүй байсан гэж шийдвэрлэсэн.

Хэлэлцүүлэг: Монголд нэр төрийн эсрэг аялал жуулчлал хөгжих эсрдэл бий юу? Үүнийг шийдвэрлэх ямар боломжууд бий вэ?

Дамжуулагчийн хариуцлага

- Уламжлалт эрх зүйгээр ямарваа нэр төрд халдсан мэдээллийг түгээхэд оролцсон бүх этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх боломжтой. Зарим улс оронд тухайн мэдээлэл нь нэр төрд халдсан агуулгатайг нь мэдэлгүй түгээсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэдэггүй. Гэхдээ энэ асуудлыг улс бүрт өөр өөрөөр авч үздэг.

- *Жишээ:* Италийн шүүх Гүүглийн ахлах ажилтнуудын нэгийг одоо ажиллахаа больсон Google Video-д хэрэглэгчийн видеог тавьсан хэмээн шийтгэл ноогдуулсан. Энэхүү видео нь хөгжлийн бэрхшээлтэй нэг ангийнхаа хүүхдийг дөрвөн өсвөр насны хүүхдүүд дээрэлхэж буй сэртхийм видео байсан юм. Энэ видеог Гүүгл хэдхэн цагийн дотор буулгаж, устгасан ч компанийн дээд удирдлагыг эрүүгийн шинж чанартай хүний нэр төрд халдсан, хувийн нууцыг задруулсан хэргээр шүүхэд хэрэг үүсгэсэн. Нэр төрд халдах асуудлыг хэрэгсэхгүй болгуулж чадсан ч хувийн нууцыг задруулсан дээр Гүүгл хариуцага хүлээсэн.
- Зарим улс орнуудад интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниудыг хамгаалах тусгай дүрэм хэрэгждэг.
- *Жишээ:* АНУ-д 1996 оны Харилцаа холбооны тухай хууль (ихэнхдээ хүмүүс үүнийг Харилцаа холбооны зохистой байдлын тухай хууль гэдэг) нь үйлчилгээ үзүүлж буй хүмүүс ч, хэрэглэгчдийг ч ижил хамгаалсан заалттай: “Мэдээллийн агуулгыг өөр хүн, байгууллага гаргасан бол тухайн мэдээллийг уншсан, хэрэглэсэн, эсвэл интерактив үйлчилгээ үзүүлж буй интернэтийн үйлчилгээгээр хангасан этгээд энэ мэдээллийн хариуцлагыг үүрэхгүй.”
 - Их Британид интернэтийн мөн чанарыг харгалзан үзсэн дүрмүүд боловсруулсан ба мэдээлэл, дуу авиаг цахим хэлбэрээр хэвлэн нийтлэх, ямартаа цахим талбараар үүнийг боловсруулах, хувилах, түгээх, худалдаалах болон цахим хэлбэрээр үүнийг боловсруулах, хувилах, түгээх эсвэл хэрэглэхэд шаардагдах тоног төхөөрөмж, систем, үйлчилгээгээр хангахыг хуулиар хамгаалсан. Ингэснээр ихэнх интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниуд болон бусад дамжуулагч этгээдүүд хамгаалагдсан ч нэр төрд халдсан мэдээлэл гэдгийг мэдсэн, эсвэл үүнээс сэргийлэх зохих ёсны арга хэмжээ аваагүй тохиолдолд хариуцлага хүлээх хэвээр.
- Европын холбоог багтаагаад бусад улс оронд агуулга байршуулах үйлчилгээ үзүүлдэг интернэтийн компаниуд мөн хамгаалагдсан ч хууль бус үйл ажиллагааны талаар мэдээлэл авсан хэрнээ тухайн мэдээллийг шуурхай устгаагүй тохиолдолд хариуцлага үүрэх зохицуулалт хэрэгждэг. Энэ нь “мэдэгдэл хүргүүлэх, хаах” заалт. Ихэнхдээ мэдэгдэл хүргүүлсэн тохиолдолд тухайн материалыг хууль бус эсэхийг шалгалгүй устгадаг нь асуудал үүсгэдэг нь оюуны өмчийн зохицуулалттай адил сорилт болдог. Жишээ нь хэрэглэгчийн үүсгэсэн агуулгыг байршуулдаг хэвлэл мэдээллийн хувьд “мэдэгдэл хүргүүлэх, хаах” зарчим нь нэр төрд халдсан гэсэн мэдэгдлийг хүлээж авсан л бол тухайн асуудал нэр төрд халдсан хэмээн тогтоогдвол хариуцлага үүрэх нь тодорхой байдаг. Ихэнх улсад нэр төрд халдах асуудлын хуулийн зохицуулалт ярвигтай байдгаас ялагдал хүлээх ба төлөх хохирлыг ч тооцсон, хэрэглэгчийн үүсгэсэн агуулгын үнэн зөвийг баталгаажуулах боломжгүй учир ийм мэдээллийн

төлөө хэвлэл мэдээлэл ихэнхдээ хариуцлага үүрэхийг хүсдэггүйг ч тооцсон тухайн мэдээлэл хууль бас үгүйг үл хайрхан ийм мэдэгдэл авсан л бол тухайн материалыг шууд устгах нь бараг гарцаагүй байдаг.

- 2005 оны хамтарсан тунхаглалдаа Тусгай илтгэгчид “мэдэгдэл хүргүүлэх, хаах” аргачлалын асуудалтай мөн чанарын тухай ийн мэдэгдсэн:

Хэн ч интернэтэд өөрийн бичээгүй агуулгын төлөө хариуцлага үүрэх ёсгүй. Харин тухайн өөрийн бичээгүй мэдээллийг өөрийнх хэмээн үзсэн, эсвэл тухайн материалыг устгах шүүхийн шийдвэрийг дагаагүй тохиолдолд хариуцлага үүрнэ.

- Цаашид хэрэгжүүлэх боломжийг нь судлах ёстой нэг арга бол “Мэдэгдэл хүргүүлэх, мэдэгдэл хүргүүлэх” арга. Энэ нь нэр төрд халдсан байх боломжтой мэдэгдлийг үйлчилгээ үзүүлэгч мэдээллийг анх түгээсэн хүнд хүргүүлэх тогтолцоо юм. Мэдэгдлийг аваад тухайн хүн өөрийн хэвлэн нийтэлснийг хамгаалах (энэ тохиолдолд нэрээ нууцлах боломж үлдэхгүй байх магадлалтай) эсвэл тухайн материалыг устгахыг зөвшөөрөх хоёр сонголттой байдаг.

Хэлэлцүүлэг: Монголын нөхцөлд хариуцлагын ямар дүрэм байвал зохимжтой вэ? Мэдэгдэл хүргүүлэх, мэдэгдэл хүргүүлэх арга нь боломжтой юу, хэрэглэхэд хэцүү байх уу?

Блоклох, шүүлтүүрдэх, хаах

- Блоклох гэдэг нь тодорхой вэбсайтуудын хандалтыг хаах арга. Энэ нь сонинг хаахтай адил арга хэмжээ ба хааяа л, зөвхөн шүүхийн шийдвэрээр хийгддэг зүйл.
- Шүүлтүүрдэх гэдэг нь тодорхой үг, хэллэг, зургийг “хэрэггүй” агуулга хэмээн үзэж, эдгээрийг шүүж, хайлтад гаргахгүй байх арга. Энэ нь зөвхөн хүсч буй мэдээллээс гадна бусад олон мэдээллийг хааж болдог бүдүүлэг арга. Олон улсын хэм хэмжээний дагуу төрөөс шүүлтүүр ашиглах нь хууль ёсны бус хэмээн үзэгддэг.
- Онцгой байдал зарлагдсан ч интернэтийг хаах нь олон хүний хувьд дэндүү чухал зүйл утгаараа мөн л хууль бус хэмээн тооцогддог. 2010 оныхоо хамтарсан тунхаглалд Тусгай илтгэгчид хэлэхдээ:

Интернэтийг нийт хүн амдаа, эсвэл зарим хүмүүсийн хувьд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хаах явдлыг нийтийн дэг журам, үндэсний аюулгүй байдал гэх мэт үндэслэлийг үл харгалзан хэзээ ч зөвтгөх ёсгүй. Энэхүү зарчим интернэтийн бүхэл эсвэл хэсэгчлэн хурд сааруулах дээр ижил үйлчилнэ.

Хэлэлцүүлэг: Улс орнуудад интернэтийн агуулгыг зохицуулах бараг л боломжгүй. Бид хэрхэн хүүхдүүдээ болон бусад хүмүүсийг интернэт дэх гэм хор бүхий агуулгаас хамгаалах вэ? Боловсрол хангалттай юу?

Ном зүй

1. Хууль ба ардчилал төв, *Дэлхий даяарх жинхэнэ сүлжээ: хүний эрхийн үүднээс интернэтийг үнэлэх нь* (2012). Дараах холбоосоор бий: <http://www.law-democracy.org/wp-content/uploads/2012/04/final-Internet.pdf>.
2. Үзэл бодлоо илэрхийлэх олон улсын Тусгай илтгэгчдийн 2011, 2015 онуудын хамтарсан тунхаглал. Дараах холбоосоор бий: <http://www.osce.org/fom/66176>.
3. Европын зөвлөл, *Интернэтийн эрх чөлөөний талаарх тунхаглал*, 7-р зарчим (2003). Дараах холбоосоор бий: http://www.coe.int/t/information/society/documents/Freedom%20of%20communication%20on%20the%20Internet_en.pdf.
4. Олон улсын харилцаа холбооны холбоо, *Мэдээллийн нийгмийг хэмжих нь* (2011 он, Женев хот). Дараах холбоосоор бий: <http://www.itu.int/net/pressoffice/backgrounders/general/pdf/5.pdf>.
5. “Интернэтийн эрхүүд ба зарчмууд” хөдөлгөөнт эвсэл, *Интернэт дэх хүний эрх ба зарчмын тунхаг*. Дараах холбоосоор бий: <http://irpcharter.org/charter/>.
6. Хууль ба ардчилал төв, *Интернэт дэх хүний эрх ба зарчмын тунхагийн тайлбар*. Дараах холбоосоор бий: <http://www.law-democracy.org/live/commentary-on-internet-rights-and-principles-charter>

Цахим орон зайтай холбоотой дасгал ажил